

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2026 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 15-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ДЭД ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ДЭД ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 – 3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4 – 67

1. *Аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэлт, хөрөнгө оруулалт, бизнесийн орчин, тулгамдаж буй асуудлын талаар мэдээлэл сонсох*

4 – 67

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Аялал жуулчлалын хөгжлийн дэд хорооны 4 дүгээр сарын 15-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Аялал жуулчлалын хөгжлийн дэд хорооны дарга Н.Батсүмбэрэл ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 6 гишүүнээс 4 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 17 цаг 12 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Г.Лувсанжамц.

Нэг.Аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэлт, хөрөнгө оруулалт, бизнесийн орчин, тулгамдаж буй асуудлын талаар мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын газрын дарга В.Батчимэг, Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны ерөнхийлөгч Т.Баттулга, Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны дэд ерөнхийлөгч В.Батзориг, Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны гүйцэтгэх захирал М.Нарангэрэл, мөн холбооны Жуулчны баазын салбар холбооны тэргүүн С.Алтантуяа, Солонгос зах зээлийн салбар холбооны тэргүүн Э.Наранхүү, Жуулчин тээврийн салбар холбооны тэргүүн Б.Ижилмөрөн, “Монгол Улсын Аялал жуулчлалын холбоо” төрийн бус байгууллагын ерөнхийлөгч С.Баясгалан, “One Mongolia Group”-ийн ерөнхийлөгч С.Амгаланбат, “Хүннү Эйр” компанийн захирал П.Мөнхжаргал, “Дөрвөн Бэрх” жуулчны баазын захирал Г.Алтаншагай, “IBIS Styles” зочид буудлын захирал Б.Түвшинжаргал нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Т.Билэг-Өрнөх нар байлцав.

Аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэлт, хөрөнгө оруулалт, бизнесийн орчинд тулгамдаж буй асуудлын талаарх мэдээллийг Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны гүйцэтгэх захирал М.Нарангэрэл, “Монгол Улсын Аялал жуулчлалын холбоо” төрийн бус байгууллагын ерөнхийлөгч С.Баясгалан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын газрын дарга В.Батчимэг нар танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд, М.Энхцэцэг, Б.Тулга, Н.Батсүмбэрэл нарын тавьсан асуултад Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын газрын дарга В.Батчимэг, Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны гүйцэтгэх

захирал М.Нарангэрэл, “Монгол Улсын Аялал жуулчлалын холбоо” төрийн бус байгууллагын ерөнхийлөгч С.Баясгалан, Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны ерөнхийлөгч Т.Баттулга, Жуулчны баазын салбар холбооны тэргүүн С.Алтантуяа, Солонгос зах зээлийн салбар холбооны тэргүүн Э.Наранхүү, “Хүннү Эйр” компанийн захирал П.Мөнхжаргал, “One Mongolia Group”-ийн ерөнхийлөгч С.Амгаланбат, “Дөрвөн Бэрх” жуулчны баазын захирал Г.Алтаншагай, “IBIS Styles” зочид буудлын захирал Б.Түвшинжаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд, Б.Тулга, Н.Батсүмбэрэл нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэлт, хөрөнгө оруулалт, бизнесийн орчин, тулгамдаж буй асуудлын талаарх мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 19 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Дэд хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 12 минут үргэлжилж, 6 гишүүнээс 5 гишүүн хүрэлцэн ирж, 88.3 хувийн ирцтэйгээр 19 цаг 24 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН
ДЭД ХОРООНЫ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “ҮНДСЭН ХУУЛЬ” танхим
17 цаг 12 минут

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Батсүмбэрэл: Дэд хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амрыг айлтгая.

Дэд хорооны гишүүн Р.Батболд, Н.Батсүмбэрэл, Э.Одбаяр, М.Энхцэцэг нар хуралд ирсэн байна. Ирц хүрсэнийг үүгээр мэдэгдье.

Дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудалыг танилцуулъя.

Аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэлт, хөрөнгө оруулалт, бизнесийн орчин, тулгамдаж байгаа асуудлын талаар өнөөдөр мэдээлэл сонсоно.

Хэлэлцэх асуудалтай холбоотой өөр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Одоо хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэлт, хөрөнгө оруулалт, бизнесийн орчин, тулгамдаж буй асуудлын талаар мэдээлэл сонсох

Аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэлт, хөрөнгө оруулалт, бизнесийн орчинд тулгамдаж буй асуудлын талаар мэдээлэл сонсоно.

Мэдээллийг Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны гүйцэтгэх захирал М.Нарангэрэл танилцуулна таныг урьж байна.

Индрийн микрофон нээе.

М.Нарангэрэл: Сайн байцгаана уу? Эрхэм хүндэт Их Хурлын гишүүд, Аялал жуулчлалын хөгжүүлэх хорооны гишүүд Та бүхэнд, мөн мэргэжлийн холбоодын төлөөлөлдөө энэ өдрийн мэндийг хүргэе.

Аялал жуулчлалын салбарын бүтээгдэхүүн хөгжүүлэлт тулгамдаж байгаа асуудлуудын талаар Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны гүйцэтгэх захирал М.Нарангэрэл илтгэл тавих гэж байна.

Аялал жуулчлалын салбарын танилцуулгыг хийхийн өмнө Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны танилцуулгыг товч танилцуулъя.

Тус мэргэжлийн холбоонд 18 мэргэжлийн салбар холбоонд өнөөдрийн байдлаар 891 аж ахуйн нэгж, 500 гаруй аялал жуулчлалын салбарын бизнес эрхлэгчид, нийтдээ 1000 гаруй хүний бүрэлдэхүүн гишүүнчлэлтэй ийм байгууллага танилцуулга хийх гэж байна.

“Аялал жуулчлалын салбарын үндэсний онцлогийг эрхэмлэсэн аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн хөтөч” гэсэн эрхэм зорилготой.

“Монгол брэндийг дэлхийд таниулж, үндэсний баялгийг нэмэгдүүлнэ” гэсэн алсын хараатайгаар Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо үйл ажиллагаа явуулж байна.

Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд Аялал жуулчлалын мэргэжлийн холбоог нийтийн эрх зүйн хуулийн этгээд байна гэж хуульчилсан байгаа.

Нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь Захиргааны хууль болон Иргэний хууль, хуулийн этгээдийн бүртгэлийн дагуу тухайн салбарт үүсгэн байгуулагдсан ийм нийтийн эрх зүйн хуулийн этгээд байна.

Хуулийн 26.1-д зааснаар аялал жуулчлалын салбарын нэгдлийг агуулсан нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн нэрийг Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо гэсэн энэ тодотголтойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Мөн бид хуульд заасан үндэслэлээр байгуулагдаж төрөөс хараат бус байх, өөрсдийн гишүүнчлэлтэй байх, хуулиар тодорхой чиг үүргийг эрх шилжүүлж авах гэсэн үндсэн 4 шинжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Мөн бусад нийтийн эрх зүй, хуулийн этгээдийн адилаар Монгол Улсад 8 дахь нийтийн эрх зүйн хуулийн этгээд болж бүртгэгдсэн байна.

Аялал жуулчлалын тухай хуульд нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн талаарх хэд хэдэн заалтууд байгаа.

Энэ мэргэжлийн холбоог үүсгэн байгуулах хурлыг Аялал жуулчлалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн шилжилтийн юугаар Байгаль орчин, аялал, жуулчлалын яам хариуцаж салбарын бүх оролцогчдыг нэгтгэж үүсгэн байгуулсан байгаа.

Мөн тухайн Аялал жуулчлалын тухай хуульдаа бид–

- аялал жуулчлалын байгууллагуудыг бүртгэх,
- нутгийн иргэдийг түшиглэсэн аялал жуулчлалыг бүртгэх,
- жуулчны хөтөч, тайлбарлагчийн үнэмлэх олгох,

-Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хороонд өөрийн 5 төлөөллийг оролцуулж, бусад салбар дундын хамтын ажиллагааг хангаж ажиллах чиглэлээр мөн хуулийн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Тэгээд аялал жуулчлалын тухай үйл ажиллагаанд тавих төрийн хяналт болон олон нийтийн хяналтыг гүйцэтгэх үндсэн чиг үүрэгтэй.

Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны эрх зүйн орчны дагуу Монгол Улсын Засгийн газрын 370 дугаар тогтоол Монгол Улсыг олон улсад сурталчлах, хүний нөөцийн сургалт, судалгааг боловсруулах, хэрэгжүүлэх, хууль эрх зүйн хуулиар олгогдсон бусад чиг үүргүүдийг гүйцэтгэхийг Засгийн газрын тогтоолоор баталж өгсөн.

Үүний дагуу Байгаль орчин, аялал, жуулчлалын яам Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Соёл, спорт, аялал жуулчлалын сайд нартай төрийн зарим чиг үүргийг гэрээгээр хариуцаж үйл ажиллагаагаа явуулж байна.

Үйл ажиллагааны чиглэл нь байгууллагуудаа бүртгэдэг,

- зочид буудал,
- жуулчны бааз,
- аялал жуулчлалын цогцолборын ангилал зэрэглэл тогтоодог,

— жуулчны хөтөч, тайлбарлагчид мэргэжлийн үнэмлэх олгодог.

Зарим тохиолдолд жуулчин тээврийн стандартад нийцээгүй тээврүүдийн зөвшөөрлийг олгох, жолооч нарыг бүртгэх,

- Монгол Улсаа олон улсад сурталчлах,
- аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх,
- сургалт, зөвлөгөө үзүүлэх,
- олон улсын стандарт нэвтрүүлж хэрэгжүүлэх,
- салбарын мэдээ, мэдээллийг шинэчлэлээр хангах –

— гэсэн чиглэлд үйл ажиллагаагаа явуулж байна.

Аялал жуулчлалын байгууллагын бүртгэлийг –

- Монгол Улс руу ирэх аяллын компани,
- Монгол Улсаас гадагшаа аялал зохион байгуулах компани,
- Орон нутгийн аялал жуулчлалын компани,
- Интернэйшнл буюу олон улсад үйл ажиллагаа явуулах

-гэсэн 4 аялал жуулчлалын байгууллагын зэрэглэлийн дагуу бүртгэлийг хийж, гэрчилгээг олгодог.

Мөн Монгол Улсын Засгийн газраас батлагдсан одны зэрэглэл олгох журмыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Мөн мэргэжлийн ажилчдад шалгалтыг зохион байгуулж, ажил, мэргэжлийнх нь үнэмлэхийг олгох асуудлыг хариуцаж ажиллаж байна.

Монгол Улсыг олон улсад сурталчлах үйл ажиллагаа нь буюу аялал жуулчлалын салбарын үндсэн жуулчин нийлүүлэх гэрээг хийгддэг 10 үзэсгэлэнд Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо сүүлийн 3 жилд тогтмол оролцож байна.

Үүний үр дүнд аялал жуулчлалын салбарт жуулчдын тоо өсөх, Монгол Улсыг эерэг сэтгэлээр олон улсад сурталчлах үйл ажиллагаанд нэлээн үүрэг рольтой харьяа яамтайгаа хамтарч ажилласан.

Аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэх төрөл дээр бид 4 улирлын аялал жуулчлалын концепцыг Засгийн газарт оруулж, аялал жуулчлалын бүтээгдэхүүнд цаашдаа энэ өвлийн аялал жуулчлал, зуны улирлаас бусад завсрын улирлуудад аялал жуулчлалын бүтээгдэхүүнүүдийг төрөлжин хөгжүүлэх, эвент арга хэмжээг зохион байгуулах нь аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэлтэд тодорхой хувь нэмэр оруулах юм байна гэсэн бодлогыг Засгийн газарт оруулж батлуулсан байгаа.

Өвлийн аялал жуулчлалын хөтөлбөрийг Аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хороо баталж хэрэгжүүлж байна.

Мөн аялал жуулчлалын салбарт сургалт, зөвлөгөө үзүүлэх чиглэлээр олон улсын нэр хүндтэй их, дээд сургууль, зочлох үйлчилгээний чиглэлээр мэргэшсэн сургалт, судалгааны төвүүдтэй хамтран ажиллаж салбарын оролцогчдыг мэргэжлийн сургалтаар байнга хангаж байна.

Үүн дотроо ялангуяа аялал жуулчлалын салбарт “startup” буюу шинэ залуу компаниудыг бойжуулах тал дээр нэлээн ажил санаачлаад ажиллаж байна.

Олон улсын хамтын ажиллагааг бид сургалт хүний нөөц дээр Бүгд Найрамдах Солонгос Улсын буцалтгүй тусламжаар Яармагт баригдсан “Аялал жуулчлалын сургалтын төв”-ийг Солонгосын КОЙКА олон улсын байгууллагатай хамтарч хэрэгжүүлэхээр 5 жилийн санамж бичигт гарын үсэг зурсан.

Мөн ЖАЙКА олон улсын байгууллагатай олон улсын шилдэг стандартыг нэвтрүүлэх чиглэлийн хүрээнд “**Green Destinations**”, “**UN Best Tourism Villages**” гэсэн төслүүдийг 2 жилийн хугацаанд Төв аймаг, Сэлэнгэ аймаг, Дархан аймаг, Өмнөговь аймагт хэрэгжүүлэхээр мөн санамж бичигт гарын үсэг зуран хамтран ажиллаж байна.

Аялал жуулчлалын салбарын мэдээ, мэдээллийг шуурхай хүргэх, жуулчдын тоо, статистик баримтыг өдөр өдөрт нь нэгтгэн гаргаж вебсайт болон пэйж хуудсуудаар байнга явуулж байна.

Мөн цахим хуудсанд тухайн жилдээ хийж хэрэгжүүлсэн ажлын тайлангуудыг онлайн байршуулснаар салбарынхандаа мэдээ, мэдээллийг нэлээн шуурхай байдлаар хүргэж байна гэсэн үг.

Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны нийт гишүүдийн тоо 891 байна. Үүнээс тур оператор компани дийлэнхийг эзэлж байна. Яваандаа жуулчны бааз, зочид буудлуудын гишүүнчлэл нэмэгдсэнээр цаашдаа 3 мянга орчим аж ахуйн нэгжийг хамарсан нийтийн эрх зүйн хуулийн этгээд болох төлөвтэй байна.

Үүн дотроо бид Монгол Улсаас Герман Улсад өөрийн салбар холбоог байгуулсан.

Мэргэжлийн 17 салбар холбоотой, ажлын албанд 14 хүн ажиллаж байна.

Салбар холбоодыг дотор нь ангилбал тухайн зорилтот зах зээл дээр ажиллаж байгаа Солонгос, Япон, Хятад, Америк, мөн гадагшаа аяллын зах зээлийн салбар холбоод байдаг бол мэргэжлийн салбар холбоод болох тухайн салбарын боловсрол, хөгжлийн нийгэмлэгт харьяатай эрдэмтэн, багш, судлаачид, мөн –

- Монголын жуулчин тээврийн холбоо,
- Адал явдалт аялал жуулчлалын эрхлэгчдийн холбоо,
- Жуулчны бааз, байршуулах хэрэгслийн холбоо,
- Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчдын холбоо –

— гэсэн холбоодуудыг нэгтгэж ажиллаж байна.

Аймгуудаас нийтдээ 6 аймагтай хамтарч ажиллаж байна.

Төв аймаг, Сэлэнгэ, Нутгийн иргэдийг түшиглэсэн аялал жуулчлал Эрхлэгчдийн холбоо, Дорноговь, Архангай, Булган аймаг гэсэн.

Энэ 17 мэргэжлийн салбар холбоод нэг дор нэгдэж Аялал жуулчлалын мэргэжлийн холбоог хамтарч цаашдаа үйл ажиллагаагаа төлөвлөж явуулж байна.

Бүтэц зохион байгуулалтын хувьд салбар өөрөө дотроосоо сонгуулиа хийж томилгоогоо явдаг. Ямарваа нэгэн төрөөс томилгоо байхгүй. Цэвэр салбарын бизнес эрхлэгчдээс бүрдсэн удирдлагын зохион байгуулалттай ажиллаж байна.

Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны тоон үзүүлэлт гэвэл нийтдээ бид 800 гаруй гишүүнээс 14 олон улсын үзэсгэлэнд оролцож, 89 байгууллагатай хамтын ажиллагаатай.

Тэгээд нийтдээ 16 аймгийн Засаг даргатай санамж бичиг байгуулж, тухайн салбарт аялал жуулчлалын салбарын бодлогыг хэрэгжүүлэх үүднээс тухайн бүс нутагт очиж ажилладаг ийм бүтэцтэйгээр ажиллаж байна.

Аялал жуулчлалын салбарын стратегийг боловсруулах хүрээнд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамтайгаа хамтарч ажиллаад дараах 14 зорилт, арга хэмжээг Засгийн газарт танилцуулсан. Үүнд:

- ▷ **Нэгд**, агаарын тээвэр.
- ▷ **Хоёрт**, дэд бүтцийн хөгжил.
- ▷ **Гуравт**, аялал жуулчлалын хөгжлийн шинэ кластер, аялал жуулчлалын үйлчилгээг сайжруулах,
 - баяр наадам, эвент арга хэмжээг боловсронгуй болгох,
 - цахим шилжилт ба сошиал эко системийг бий болгох,
 - маркетинг, зар сурталчилгааг идэвхжүүлэх,
 - аяллын худалдааг идэвхжүүлэх,
 - зохион байгуулалт болон засаглалын оновчтой хэлбэрүүд,
 - хууль эрх зүйн зохицуулалтууд,
 - MICE¹ болон тусгай сонирхлын сегментийг хөгжүүлэх, дотоодын... /минут дуусав/

Н.Батсүмбэрэл: Гүйцээж танилцуулъя. Микрофон нээе.

М.Нарангэрэл: Дотоодын аялал жуулчлалын хөгжил, Өвлийн аялал жуулчлал, тогтвортой хөгжил гэсэн үндсэн 14 стратегийг боловсруулсан.

Тэгээд жуулчдын сонирхолд Монгол орны талаарх ямар ойлголт, мэдээллүүд сөргөөр нөлөөлж байгаа вэ гэдэг судалгааг олон улсын байгууллагуудаар хийлгэж авч үзсэн.

Энэ дээр манай замын нөхцөл байдал, дотоодын нислэгээс болгоомжилсон шалтгаан 70 орчим хувийг “хүндрэлтэй байна” гэж жуулчид үзсэн бол эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар болон аюулгүй байдалд нийцэхгүй, эд нарт итгэхгүй байна гэсэн санал, сэтгэгдлийг 70 хувь нь өгсөн байна.

¹ Meetings, Incentives, Conferences, Exhibitions/Events (MICE)

Тэгээд “өвөл нь их хүйтэн”, “аюулгүй, тайван газар биш” гэж үзсэн. Тур операторуудад илүү найддаг бол “бие дааж чөлөөт аялал явуулах боломжгүй бүс нутаг” гэж үзсэн байна.

Тэгээд манай улсаас шууд нислэг тухайн улс орнуудад байхгүй, дандаа дамжих нислэг хийгддэг гэсэн ийм шалтгааныг 62 хувьтай, нийт 12 мянган жуулчнаас санал асуулгыг авахад ийм үр дүн бидэнд үзүүлсэн байна.

Тэгээд стратегийн түвшинд 13 орныг бид Монгол Улс руу аялахад хамгийн тохиромжтой гэж эрэмбэлэн тодорхойлсон.

Эдгээр улс орнуудын нэрийг дурдвал –

■ Нэгдүгээр түвшний зах зээлд–

- Оросын Холбооны Улс,
- Хятад,
- Солонгос,
- Америкийн Нэгдсэн Улс,
- Холбооны Бүгд Найрамдах Герман Улс,

■ Хоёрдугаар түвшний зах зээлд –

- Япон,
- Турк,
- Их Британи,
- Франц,
- Казакстан,

■ Гуравдугаар түвшний зах зээлд –

- Энэтхэг,
- Зүүн Өмнөд Ази,
- Ойрх Дорнод –

— гэсэн энэ 3 сегментийг бид зах зээл дээр тодорхойлж тавьсан.

Эдгээр улсууд нийтдээ жишээлбэл, нэгдүгээр түвшинд байгаа зах зээлийнх дэлхийн нийт **outbound**_[гарах аялал жуулчлал] зах зээлийн –

- аялалд эзэлж байгаа хувь нь 45 хувь,
- дэлхийн аялал жуулчлалын нийт орлогод эзлэх хувь нь 50 хувь,
- Монгол Улсын аялалд эзэлж байгаа хувь нь 92 хувьтай –

-ийм улс орнуудыг бид сонгож ажиллаж байна.

Монгол Улсын хувьд тэргүүлэх ач холбогдолтой жуулчны 7 сегментийг тодорхойлсон.

- ▶ **Нэгдүгээрт нь**, Соёлын залуу аялагч буюу насны хувьд Монгол Улс настай, тэтгэврийн насны иргэдэд аяллаа борлуулдаг байсан бол бид илүү залуу аялагч руу шилжсэн.

Энэ нь манай улсыг сурталчилж байгаа нөлөөлөгч нар болон бусад маркетингийн зорилтот контентуудын үр дүнд бий болж байгаа үр дүн байна.

- ▶ **Хоёрдугаарт нь**, Өрнийн ахмад аялагч нар мэдээж бидэнд тодорхой уламжлалт зах зээлүүд байгаа.

Дорнын ахмад аялагч нартай бид нэлээн олон жил хамтарч ажилласан байдаг.

Мөн Монгол орон байгалийн адал явдлын өгөгдөлтэй тийм идэвхтэй аялагч нарын хувьд адал явдалт аяллыг бүрдүүлэх хэмжээний нэлээн олон активити бүтээгдэхүүний төрөлтэй.

Мөн гайхамшгийг эрэлхийлэгч гэр бүлүүдэд зориулсан, дурсамж бүтээгч залуу гэр бүл, ганцаарчилсан буюу шашин, мөргөл, сүсэг бишрэлтэй хүмүүсийн бүтээгдэхүүнүүдэд зориулсан аяллыг төлөвлөж ажиллаж байна.

Зорилтуудын хэрэгжилт ахиц дэвшлийн явцыг хянахад бид дараах байдлаар тодорхойлсон байгаа.

Нэгдүгээрт, агаарын тээврийн хүртээмж. Манай агаарын тээврийн нисэх буудлуудын хүчин чадал. Мөн дотоодын нислэгийн хүртээмж зэргийг бид дараах асуудлуудыг нэлээн сайжруулах шаардлагатай гэж үзэж байгаа.

Дэд бүтцийн хөгжил, зочид буудлуудыг эрэмбэлэх, тэгээд орны тоог нэмэгдүүлэх, завсрын улирлуудын орны дүүргэлтийг хангах, аялал жуулчлалын шинэ кластер буюу бусад улс орнуудын хувьд дамжин өнгөрөх транзит байх, эсвэл хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх гэсэн ийм шинэ кластеруудыг бид бий болгох шаардлагатай гэж үзэж байгаа.

Аяллын үйлчилгээгээ сайжруулах.

Баяр наадам, эвент арга хэмжээн дээр бид нэлээн ач холбогдлоо өгдөг. Яагаад гэхээр аялал жуулчлалын бүтээгдэхүүний тодорхой хувь нь энэ эвент арга хэмжээнүүдээр идэвхжиж ирдэг учраас бид өвлийн улирлуудад эвентүүдээ илүү орон нутгууд руу тараах, дотоодын аялал жуулчлалыг орон нутгийн эвентүүдээр дамжуулан хөгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байгаа.

Цахим шилжилт ба социал-эко системийг бид ер нь Монгол орныг сурталчилж байгаа вебсайт, аппликэйшн платформ яг үндэсний хэмжээнд бусад улсуудынх шиг байхгүй байгаа.

Тэгээд Дэлхийн банкнаас “УХААЛАГ ЗАСАГ” хөтөлбөрийн хүрээнд энэ төслийг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамтай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байгаа.

Монголын аялал жуулчлалын сонирхлын түвшин жил бүр маркетингийн зардлуудыг бид тодорхой төсөв тавьж тогтмол хэрэгжүүлэхгүй бол тодорхой хэмжээнд аялал жуулчлалын бүтээгдэхүүн гэдэг бол дандаа нөлөөлөл, социал, тэгээд идэвхтэй эвент арга хэмжээгээр Монголыг таньж мэдэх энэ үйл явц нь явагддаг учраас энэ зардлуудыг бид чухал гэж үзэж байна.

Аяллын худалдааг бид гадаад дахь төлөөлөгчийн тоо, мөн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч нар, тэгээд мөн **Famed Tour**_[танилцах аялал]-уудийн аяллын тоогоор бид тодорхой зорилтод хүрэх нь зүйтэй гэж үзэж байгаа.

Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны гүйцэтгэх чиг үүргийн тоо, аялал жуулчлалын Хөрөнгө оруулалтын зөвлөл жилдээ бид Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас 20-иос 25 төсөл, хөтөлбөрийг 18 салбар холбооны үйл ажиллагааны зардалд зориулж батлуулж авч байгаа.

Эрх бүхий бүртгэлтэй тур операторуудын эзлэх хувь Аялал жуулчлалын тухай хууль шинэчлэн найруулагдсанаас хойш маш сайжирсан. Хуучин бүртгэгддэггүй байсан. Дандаа хувиараа явдаг байсан... /минут дуусав/

Н.Батсүмбэрэл: Шуурхай, товч танилцуулаарай. Сунгаад микрофон нээе.

М.Нарангэрэл: Хуучин бүртгэлгүй байсан жуулчны компаниудын бүртгэл нэлээн сайжирсан.

Хоёрдугаарт, цахим виз бүхий зохицуулалттай орнуудын тоо жил болгон сунгагдаж байна.

Тэгээд тусгай сонирхлын аяллыг зохион байгуулахын тулд MICE болон хурал, арга хэмжээг бид олон улсын эвент, спортын эвентүүд, соёлын эвентүүдтэй хамтарч томоохон багцуудыг хөгжүүлэх дээр нэлээн ажиллаж байна.

Мөн гадагшаа аялах зардлыг багасгаж, дотоодын аялал жуулчлалыг эрчимжүүлэх энэ ажил дээр нэлээн бодлого, төлөвлөлт байх ёстой гэж үзэж байгаа.

Өвлийн аялал жуулчлал, тогтвортой хөгжил буюу байгаль орчин, экологид аялал жуулчлалын салбараас үзүүлэх нөлөөллийг бууруулах зүйтэй гэсэн ийм 14 шалгуур үзүүлэлтийг бид тодорхойлон ажиллаж байна.

Тэгээд мэдээж 2030 он хүртэл бид дараах үйл ажиллагаанууд нэлээн шаардлагатай байна.

- Олон улсын нислэгүүдийг нэмэгдүүлэх,
- шинэ чиглэлүүдэд нислэг үйлдэх,
- дотоодын нислэгийн холболтуудыг сайжруулах,
- дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх,
- аялал жуулчлалын хүчин чадлыг хангахад –

-чухал ач холбогдолтой хэд хэдэн асуудлуудыг бид салбарынхаа хэмжээнд өргөн хэлэлцүүлэгтэй, судалгаатай, тэгээд үүнийгээ Соёл, спорт, аялал жуулчлалын яамтайгаа жил болгон маш нарийн өндөр нягт хамтарч ажиллаж энэ үйл ажиллагаануудтай явсны үр дүнд бид жуулчдын тоогоо нэлээн идэвхжүүлж чадаж байна.

Тэгээд аялал жуулчлалын шинэ кластераар бид 2 зүйлийг нэлээн тулгуурлаж авч үзэж байгаа

- ▶ **Нэгдүгээрт нь**, түүхэн аялал жуулчлал буюу зүүн тийшээгээ аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх.
- ▶ **Хоёрдугаарт нь**, хил орчим буюу хил дамнасан аялал жуулчлалыг бид идэвхжүүлэх нь жуулчны тоог сая руу дөхөхөд хамгийн боломжтой хувилбарууд гэж харж байгаа.

Тэгээд аялал жуулчлалын үйлчлэл болон бусад үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд дараах алхмууд –

- нисэх буудал,
- нийтийн тээвэр,
- цахим хэрэглээ,
- байр сууц,
- хоол унд,
- арга хэмжээ –

-гэсэн энэ үйл явдлууд дээр илүү төвлөрч ажиллаж байна.

Цахим шилжилт дээр бид гар утасны аппликэйшн, захиалгын цахимжуулалт дээр нэлээн ажиллаж байгаа бол бусад асуудлуудыг дараах байдлаар тодорхойлж байна.

Аялал жуулчлалын салбарын бодлого, зохицуулалт нь зохион байгуулалтын хүрээнд дараах тогтвортой хөгжлийн гол хүчин зүйлүүд гэж бид харж байгаа.

Тэгэхээр энэ 4 үндсэн сегмент дээр бид бүсчилсэн хөгжил болон аймгийн Засаг дарга нар, тэгээд харьяа аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газартайгаа хамтарч ажиллаад тодорхой үр дүнд хүрч байгаа гэж харж байна.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хороонд мэргэжлийн 18 салбар холбооноос дараах 19 саналыг тавьж байгаа

- ▷ **Нэгдүгээрт нь**, агаарын тээврийн даац нэмэгдүүлж дотоодын нислэгийг тогтмолжуулахад бодлогын дэмжлэг үзүүлэх.
- ▷ **Хоёрдугаарт нь**, хөрөнгө оруулалтыг татахын тулд бид зээлийн дотация нэмэгдүүлмээр байна.
- ▷ **Гуравдугаарт нь**, цахим шилжилт хийх олон улсын төлбөр тооцооны хэрэгслийг шуурхай нэвтрүүлэх ажил.

Жишээлбэл, **PayPal** Монгол Улсад ажиллахгүй байна.

- Гадаад зар сурталчилгааныхаа маркетингийн төсвийг тогтмолжуулах,
- түлхүүр үгийг хэрхэн хэрэглэх тал дээр ойлгомжтой болох,
- олон улсын аялал жуулчлалын байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх,
- дэд бүтцийг сайжруулах,
- зам дагуу хатуу хучилттай замын төсвүүдийг Их Хурал дээр төсөв дээр батлуулж өгөх,
- хүний нөөцийн бодлого дээр бид гадаадаас ажиллах хүч оруулж ирэх тухай хуулийг батлуулах,
- жуулчин тээврийн зөвшөөрөл,
- 48 цагийн бүртгэл гэсэн –

“ЧӨЛӨӨЛЪЕ” гэдэг аян салбарт нэлээн асуудал болж байгаа 2 зөвшөөрлийн асуудлыг бид хөнгөвчилж, мэргэжлийн байгууллагууд руу шилжүүлэх, эсвэл цуцлуулах дээр бас энэ хорооноос хүсэлт гаргаж үзэж байна.

Тэгээд хамгийн сүүлд нь боомтын нэвтрэх чадамж буюу бид хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд манай боомтуудын бэлэн байдал асуудалтай байгаа тул энэ хил орчмын аялал жуулчлал, хил дамнасан аялал жуулчлалыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр чөлөөтэй зорчиход бодлогын дэмжлэг үзүүлж, холбогдох хууль, тогтоомжуудад дэмжлэг болж өгөөч ээ гэж хүсэж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Батсүмбэрэл: Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны гүйцэтгэх захирал М.Нарангэрэл танд баярлалаа.

Дараагийн танилцуулгыг “Монгол Улсын Аялал жуулчлалын холбоо” төрийн бус байгууллагын ерөнхийлөгч С.Баясгалан танилцуулна.

Таныг урьж байна. Микрофоныг нээе.

С.Баясгалан: Аялал жуулчлалын дэд хорооны эрхэм гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

“Монголын аялал жуулчлалын холбоо”-ноос өнөөдрийн энэхүү бидэнд олгож байгаа боломжид гүн талархал илэрхийлье.

Бидний хувьд 2026 оны 2 сарын 11-нээс 16-ны өдрүүдэд Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтраад “Аялал жуулчлалын долоо хоног” гэх арга хэмжээг зохион байгуулаад, үүн дээр бол яг бизнес эрхлэгчдэдээ бүх чиглэлээр нь сонссон.

Энэ дээр –

- тур операторын бизнес эрхэлж байгаа танд ямар асуудлууд байна,
- жуулчны баазын бизнес эрхэлж байгаа хүмүүст ямар асуудлууд байна,
- зочид буудлын бизнес эрхлэлт дээр ямар асуудлууд байна –

-гэх мэтчилэн чиглэлүүдээр сонсож асуудлуудыг томъёолсон байгаа.

Нийт 500-аас 600 бизнес эрхлэгчдийн цэвэр санал байгаа шүү гэдгийг Та бүхэнд танилцуулах асуудлаа томъёолж хэлмээр байна.

Мэдээж аялал жуулчлалын салбарт эхлээд хөрөнгө оруулчихсан, бизнесээ үйл ажиллагаагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийнхээ асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгаа.

Тэгээд Та бүхэнд материал түрүүлээд өгөгдсөн болохоор Та бүхэн танилцаж амжсан байх.

Аялал жуулчлалын салбар дунджаар үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд маань хөрөнгө оруулалт буюу ялангуяа манай салбарт үйл ажиллагаа явуулж байгаа нийт жуулчны баазуудын 80 хувь нь зөвхөн зуны улиралд үйл ажиллагаа явуулж байна.

- Үйл ажиллагаагаа өргөтгөх шаардлагатай байна.
 - Хөрөнгө оруулалт санхүүгийн бүтээгдэхүүн шаардлагатай байна гэж үзэж байгаа.
-

Ингээд 200-аас 500 мянган долларын хөрөнгө оруулалтыг өөрсдөө татах, шинээр төслүүд эхлэх саналуудыг ирүүлсэн. Үүнд чиглэсэн шийдвэрүүдийг төрийн зүгээс гаргаад явж байгаа.

Тийм болохоор үүнтэй холбоотой асуудлуудыг эргээд танилцуулгынхаа хүрээнд хүргэх болно. Хөрөнгө оруулалтыг юу руу чиглүүлбэл гол вэ гэхэд улирлын хамаарлыг бууруулах гэж байгаа.

Тэгээд түрүүн хэлсэнчлэн Монголд ирж байгаа жуулчдын 70 гаруй хувь нь зөвхөн зуны улиралд буюу 6-аас 10 дугаар сард ирээд байгаа.

Тэгэхээр бидний номер нэг асуудал бол улирлын хамаарлыг бууруулах, 4 улирал ажилладаг жуулчны бааз, үйлчилгээний байгууллагуудыг нэмэгдүүлэх, эдгээр тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх эдээр тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх гэдэг рүү төвлөрөх шаардлага байгаа юм.

Мэдээж татварын хөнгөлөлттэй нөхцөл, тэгээд хөнгөлөлттэй зээл, тусламж, санхүүгийн бүтээгдэхүүн, эрх зүйн орчны асуудлуудаас гадна манай салбарт тулгамдаж байгаа дараагийн асуудал бол хүний нөөцийн асуудал болж эхэлсэн. Манай салбарт мэдлэгтэй, чадвартай, гаднын жуулчдын эрэлтэд нийцсэн боловсон хүчин дутагдалтай байна.

Тэгэхээр гадаадын ажиллах хүч авч ажиллуулах гэхэд улсад төлдөг төлбөрийн хэмжээ их асуудалтай байгаа.

Тэгэхээр үүн дээр яг салбарт чиглэсэн бодлого шаардлагатай байна гэдэг.

Ингээд үзэхээр ерөнхийдөө хөрөнгө оруулалт татах, энэ салбарт үйл ажиллагаа эрхлэх сонирхол өндөр байгаа боловч төрийн бодлого, чиглэл өөрөө байгаа олохгүй байна гэсэн ийм ерөнхий дүгнэлт гарсан байгаа.

Тэгээд ерөнхийдөө цаашдаа бид 7 чиглэлд төвлөрч ажиллах нь зүйтэй юм гэсэн саналууд гарч байна.

Нэгдүгээрт, мэдээж Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас хэрэгжүүлж байгаа хөнгөлөлттэй зээл байгаа олох нь нэгдүгээр асуудал. Энэ хөнгөлөлттэй зээл дээр үүсэж байгаа асуудлуудыг Та бүхэнд товч хэлэхэд өнөөгийн байдлаар төрөөс хүүгийн татаасыг олгож байгаа.

Тэгээд аж ахуйн нэгж дээрээ жилийн 6 хувийн 6 жилийн хугацаатай зээл олгогдохоор очиж байгаа.

Тэгээд өнөөдрийн байдлаар арилжааны 10 банкуудад бараг их наяд төгрөгийн зээлийн хүсэлт ирсэн байна.

Тэгээд ингээд зээл олгогдож эхлээгүй байхад ямар байдлууд үүсэж байна вэ гэвэл зарим нэг банкаас зээлийн санхүүжилт дууссан гэсэн ийм мэдээллийг бизнес эрхлэгчдэд өгч эхэлсэн.

Тэгэхээр зээл өөрөө байгаа онож байна уу, зээлд яг аялал жуулчлалын салбарын туршлагатай аж ахуйн нэгжүүд хамрагдаж чадаж байна уу гэдэг ийм эргэлзээ үүсэж эхэлсэн.

Тэгээд өнөөдрийн байдлаар бид зүгээр зээлийн мэргэжилтэн шиг ийм байдал үүсэж байна.

Дараа нь хамгийн гол асуудал маань Улаанбаатар хотод харьцангуй бизнес эрхлэгчид өндөртэй. Орон нутагт. Одоо хоёр хоногийн өмнө Өвөрхангай аймагт ажиллаад ирсэн. Өвөрхангай аймагт нэг ширхэг ч зээл олгогдох боломжгүй ээ гэсэн банкуудын хариу ирсэн байгаа.

Тэгэхээр орон нутагт бид дөрвөн улирал ажилладаг үйлчилгээний байгууллагуудаа нэммээр байхад энэ зээлийн хүртээмж маань орон нутагтаа очиж чадахгүй байгаа гэдгийг Та бүхэн анхаараарай гэдэг энэ зүйлийг аж ахуйн нэгжүүд маань санал тавиад байгаа.

Хоёрдугаарт, 2023 оноос Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл мөрдөгдөж эхэлсэн.

Энэ шинэчилсэн найруулгын төсөл дээр одоо 2 жилийн дараа эрх зүйн орчны судалгаа, дүгнэлт хийх ёстой, анализ хийх ёстой. Энэ хууль өөрөө эрх зүйн хувьд бүрэн дүүрэн ажиллаж байна уу, ямар асуудлууд үүсээд байгаа вэ гэдэг дээр анализ хийх ёстой. Энэ хийгдээгүй байгаа.

Үүнтэй үүдэлтэй манай салбарт нэг томоохон асуудал бий. Сая өмнө танилцуулга хийсэн байгууллага маань “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” гэдэг нэртэй байгууллага байгаа.

Мэргэжлийн нэгдсэн холбооны тухай хууль 2025 оноос үйлчилж эхэлсэн.

Тэгэхдээ Дээд шүүх бүртгэх ёстой гэдэг маргаан Үндсэн хуулийн цэц дээр өгөгдсөн учраас Монгол Улсад нэг ч бизнесийн салбарт “мэргэжлийн холбоо”, “нэгдсэн холбоо” гэдэг статус Дээд шүүхээс олгоогүй байгаа.

Гэтэл энэ хуулийг угтаж 2023 оноос Соёл, спорт, аялал жуулчлалын яам одоогийн, өмнөх бол Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас төрийн төсвийг аливаа сонгон шалгаруулалтгүйгээр зөвхөн нэг шинэ холбоо байгуулаад олгодог болсон.

Ингээд жилд 4-өөс 5 гээд нийтдээ 10 хэдэн тэрбум төгрөгийн төсвийн олголтыг хийсэн. Төсвийн санхүүжилтийг хийдэг. Гэтэл эргээд тайлагналт байхгүй.

Тэгэхээр энэ татвар төлөгчдийн мөнгө зөв юм руу зарцуулагдаж байна уу, яагаад нэг газар давуу эрх олгогдоод байгаа юм бэ гэдэг асуудлууд байгаа. Монголын аялал жуулчлалын холбооны хувьд 34 дэх жилдээ үйл ажиллагаа явуулж байгаа Монголын тэргүүлэх ууган холбоо.

Тэгэхээр энэ дээр манай гишүүн байгууллагууд, тэр дундаа татвар төлөгчид эргэлзээтэй асуудлыг шийдэж өгөөч ээ гээд энэ саналыг Аялал жуулчлалын дэд хороонд тавьж байгаа.

Ингээд Засгийн газрын тогтоол гарсан байдаг. 2023 онд аялал жуулчлалын чиглэлийн үйл ажиллагаануудыг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлнэ гэдэг Засгийн газрын тогтоолтой.

Гэтэл Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо маань статусаа 2-оос 3 байдлаар тайлбарладаг.

- Аялал жуулчлалын тухай хуульд “нийтийн эрх зүйт хуулийн этгээд” гээд.
- Засгийн газрын тогтоолд нь “төрийн бус байгууллага” гээд байдаг.

Тэгээд төрийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа гээд. Нэмээд гадаад нэр дээрээ “**Аялал жуулчлалын хөгжлийн төв**” гээд яамны харьяанд байсан төрийн байгууллагын нэрийг ямар нэгэн тогтоол шийдвэргүй авч хэрэглээд олон улсад болохоор төрийн байгууллага шиг **Mongolian Tourism Organization** гэсэн ийм эргэцүүлэл, ийм өөр мэдээллийг түгээгээд явж байгаа.

Тэгэхээр үүнийг төр өөрөө шийдвэрлэж, биднийг ийм чөлөөт өрсөлдөөнд бэлдэх ёстой байх.

Бизнес, хувийн хэвшил өөрсдөө бид энгийн байдлаар үйл ажиллагаа явуулж байхад хэн нэгэн холбоог ингэж хууль өөрсдөдөө зориулж бий болгох замаар шинээр байгуулж, төрийн бүх чиг үүргийг шилжүүлж байгаа энэ тодорхой асуудлууд дээр аль нэг хуулиуд дээр зөрчилдөөн үүсэж байгаа байх аа.

Тэгэхээр энэ дээр олон аж ахуйн нэгжүүд санал ирүүлсэн. Тэгээд магадгүй энэ хурлын дараа Та бүхэнд дэлгэрэнгүй саналыг овог, нэр, хүмүүсийн хэлсэн саналтай нь хүргүүлж болно.

Аялал жуулчлалын маркетинг сурталчилгааны асуудлууд байгаа. Та бүхэн мэдэж байгаа.

Аялал жуулчлалын сурталчилгаа гээд хэдэн улс орнуудад хийгддэг үзэсгэлэн.

Дээрээс нь сүүлийн үед маш их хэмжээний зардлыг олон улсын хэвлэл мэдээллийн агентлагууд болон олон улсын нэр хүндтэй спортын багуудыг дэмжихэд чиглүүлээд үүнийгээ аялал жуулчлалын сурталчилгаа гэж нэрлэх, энэ нь эргээд хяналтгүй, үр дүнгүй байх асуудлууд гарч байгаа.

Тэгэхээр аялал жуулчлалын сурталчилгаа гэдэг нэг сурталчилгаа, нэг доллар болгоны ард нэг жуулчны асуудал яригдах ёстой.

Тэгэхээр Монгол Улсын нэр хүндийг өргөх гадаад сурталчилгаа болон аялал жуулчлалын эдийн засгийн үр ашигтай сурталчилгаа хоёроо бид ялгах шаардлагатай болж байгаа.

Тийм болохоор цаашдаа бид энэ аялал жуулчлалын сурталчилгааг хийх, нэн ялангуяа өнөөдөр энэ геополитикийн нөхцөл байдал үүслээ. Урт хугацааны, ялангуяа барууны улсуудаас ирэх жуулчид аяллаа цуцлах, үнээс шалтгаалаад хойшлуулах гээд олон нөхцөл байдал л үүсэж байна.

Тэгэхээр бид шинэ зах зээлүүд рүү сурталчилгааг чиглүүлэх хэрэгцээ шаардлага үүсэж байна. Дахиад манай салбарынхан дээр гэрээ цуцлагдах, гэрээний өрөнд орох асуудлууд үүсэж байна.

Тэгээд энэ дээр ч гэсэн бид нэгдүгээрт гадаад сурталчилгааг чиглүүлэх.

Хоёрдугаарт, Соёл, спорт, аялал жуулчлалын яамны зүгээс бодлогын яам нь геополитикийн нөхцөл байдал манай салбарт хэрхэн нөлөөлөх юм бэ, ямар эрсдэлүүд бий болох юм бэ, үүн дээр аж ахуйн нэгжүүд ямар хариу үйлдэл үзүүлэх юм бэ, эсвэл нөгөөтээгүүр бидэнд боломж бий болж байгаа юу гэдэг дээр бидэнд нэгдсэн мэдээлэл, мэдлэг, чиглэлийг мэргэжлийн эдийн засагчидтай хамт өгөх шаардлагатай байх гэж бодож байгаа.

Тэгээд гадаад сурталчилгаанаас гадна дахиад түрүүчийн өмнөх танилцуулга дээр гарлаа.

Манай салбар 2011 онд төр анх удаа энэ салбарт ямар ч тусгай зөвшөөрөлгүй болгосон ийм салбар байгаа. Гэтэл дахиад энэ шинэ байгууллага байгуулагдсанаар –

- хөтчийн үйлчилгээ эрхэлж байгаа хүмүүсийг гэрчилгээжүүлнэ,
- стандарт хангаагүй жуулчны баазуудыг гэрчилгээжүүлнэ,
- стандартын шалгалт хийнэ,
- аялал жуулчлалын байгууллага болгоноос 1 сая 200 мянган төгрөг авч гишүүнээр элсэнэ.

Гишүүнээр элсээгүй тохиолдолд хилээр жуулчин нь орж ирэх боломжгүй.

Тэгээд дээрээс нь яамны бүх газрын дарга нар сууж байна. Энэ яамны үйл ажиллагаанд зөвхөн энэ байгууллагын гишүүн байгууллагууд оролцдог болсон.

- Олон нийтэд мэдээлэл нь дэлгэрэнгүй явдаггүй.
- Бүртгэл хаалттай, мэдээллийн ил тод байдал хангагдахаа больсон.

Тэгээд цаашдаа ер нь энэ аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжүүд маань ийм шударга өрсөлдөөн хийж чадахгүй, мэдээллээс хол байх, мэдээлэл авах хэрэгцээ шаардлагаа хангаж чадахгүй ийм нөхцөл байдал бодитоор үүсээд байгаа гэдгийг хэлмээр байна.

Тэгээд улирлын хамаарлыг бууруулах дээр Та бүхэнд хэлэхэд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа нийт зочид буудлуудын ерөнхийдөө өрөө дүүргэлт 40 хувь. Өнгөрсөн онд анх удаа “**Shangri-La**” зочид буудал 40 хувийн дүүргэлтэд хүрснээ зарлалаа. Ерөнхийдөө нийт дүүргэлт 40 хувьтай байдаг.

Тэгээд өвлийн улиралд бид зочид буудлын үйл ажиллагаа маань хүлээн авалт зэрэг бусад үйл ажиллагаа нь орлогыг олдог. Гэтэл нөгөө төрийн шийдвэр гаргалт бизнес эрхлэгчдэд гэнэт хүрдэг. Тухайлбал, 2025 оны 12 сард төрийн байгууллагуудын шинэ жилийн үйл ажиллагааг зогсоосон.

Тэгээд манай зочид буудлууд бүгд шинэ жилийн захиалга цуцлагдсанаас маш их хэмжээний гэрээний өр төлбөрт орсон.

Тэгээд нэмээд нийслэлийн татвар гэж өгч байгаа. Бүх аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчид зочид буудал, жуулчны баазууд 2 хувийн татвар өгч байгаа. Заримдаа зочид буудлууд үүнийг давхардаж өгч байна. Зочид буудлын өрөөний ор хоногийн заралтаас гадна ресторан давхардсан 2, 2 хувийн татвар өгч байгаа.

Тэгэхээр нийслэлийн татвар буюу жуулчны үйлчилгээнээс авч байгаа татварыг эргээд энэ салбарыг санхүүжүүлэх, эргээд энэ өвлийн аялал жуулчлал, нэн ялангуяа Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа зочид буудлуудын өвлийн дүүргэлтийг нэмэгдүүлэхэд чиглүүлэх, өвлийн нислэгийн дотаци өгөх гэх мэтчилэн олон улсад туршигдсан сайн туршлагауудыг бид нэвтрүүлэх боломж байна.

Тэгээд жуулчдаа нэмэх боломжтой дараагийн асуудал бол бид мэдээж далайд гарцгүй улс. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа жуулчны баазад Улаанбаатар гэсэн олон улсын хилээр орж ирж байна.

Гэтэл бусад орон нутаг маань эндээс үр ашгийг хүртэх ёстой.

Энэ жил бас COP зохион байгуулагдана. 8 сард. Ингээд 8 сард бид гаднын жуулчин авч чадахгүй.

Тэгэхээр энэ **High Season**-ыхоо үрээр гаднын жуулчдыг бид хэрхэн авах вэ гэхээр орон нутгуудад олон улсын нислэгийг бий болгох шаардлага үүсэж байгаа.

Эхний захиалгууд –

- **Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас** Өмнөговь, Хөвсгөл, Ховдын чиглэл,
- **Бүгд Найрамдах Солонгос Улсаас** Хөвсгөл, Өмнөговийн чиглэлд –

-нислэгүүд үйлдэх урьдчилсан төлөвлөлт, захиалгууд явж байгаа.

Гэтэл орон нутгийн олон улсын нислэгийг жигдэртэл бидэнд ямар нэгэн бодлогын дэмжлэг байна уу?

Яагаад гэвэл олон улсын сурталчилгааг дэмий ямар нэгэн хэвлэл мэдээллийн агентлагт өгч байснаас яг олон улсын нислэгийн дотацийг жигдэртэл нь нэг жилийн хугацаанд бага хэмжээгээр дэмжвэл бидэнд хэрэгтэй байна гэдэг энэ асуудал байгаа.

Тэгээд хамгийн сүүлийн асуудал бол энэ **“Хил орчмын аялал жуулчлал”** байгаа. Хил орчмын аялал жуулчлалын 6-аас 7 нөхцөл хоёр улсын хооронд гэрээ хэлэлцээрээр зохицуулагдах ёстой.

Ингээд хамгийн сүүлийн нөхцөл хангагдахгүй 2 жил болж байна. Сүүлийн 2 жилийн хугацаанд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Хууль зүйн яам хоёр хамтраад хилийн аль боомтоор хэдэн жуулчин орж ирээд, хэдэн цаг ямар маршрутаар аялаад гарах юм бэ гэдгийг хамтарч батлах ёстой.

Тэгээд энэ нь батлагддаггүй.

Сүүлийн бичгийг аваад үзэхэд хил орчмын аялал жуулчлалын маршрутынхаа бичгийг Соёлын яамнаас Хууль зүйн яаманд хүргүүлэхдээ “хил дамнасан аялал жуулчлалын маршрут” гэж андуурч хүргүүлсэн байсан.

Тэгээд энэ бол мэргэжлийн алдаа гэж үзэж байгаа.

“Хил дамнасан аялал” гэдэг нь Монгол Улсад орж ирээд Оросын Холбооны Улс буюу бусад улс руу гарахыг хэлнэ.

Тэгэхээр энэ хил орчмын аялал жуулчлалаа нээх юм бол бид орон нутаг Улаанбаатараас эдийн засгийн хамааралтай байдлыг бууруулах маш том хэмжээний боломж юм.

Тэгэхээр үүнийг мэргэжлийн байдлаа хангаад, төр өөрөө хэрэгжүүлэх чиг үүргээ хэрэгжүүлээд энэ асуудлыг яаралтай шийдээч ээ гэж хүсмээр байна.

Тэгээд хамгийн төгсгөлд нь хамт ирсэн бүрэлдэхүүнээ танилцуулъя.

“Монголын аялал жуулчлалын холбоо”-ны удирдах зөвлөлөөс “Хүннү Эйр” компанийн захирал П.Мөнхжаргал, тэгээд аялал жуулчлалын салбарын тур операторын төлөөлөл болоод жилдээ 20 гаруй мянган жуулчин хүлээж авч байгаа “Let's travel” компанийн захирал С.Амгаланбат захирал байгаа. “IBIS Styles” зочид буудлын захирал Б.Түвшинжаргал. Тэгээд “Дөрвөн Бэрх” жуулчны баазын захирал ирсэн байна.

Тэгэхээр яг чиглэл чиглэлээр нь гишүүд маань илүү тулгамдаж байгаа асуудлуудыг асуугаасай гэж хүсэж байна.

Сүүлийн 40 секундээ ашиглаад бас нэг санал хэлэхэд COP олон улсын арга хэмжээг зохион байгуулж, хүлээж авах бүх буудлуудын 8 сар дахь өрөөг блоклосон.

Ингээд COP-ыг зохион байгуулахтай холбоотойгоор өнгөрсөн долоо хоногт нэг зочид буудал дээр 9-өөс 10 төрийн байгууллагын шалгалт давхцаж очсон байна.

Авлигатай тэмцэх газар, мал аж ахуй, нийслэлийн гээд 9 байгууллага.

Тэгэхээр энэ шалгалтаа төрийн байгууллагууд хоорондоо нэгтгээд хувийн хэвшил тээргүйгээр хийж болох уу. Тийм ээ. Ер нь яагаад стандарт хангаад үйл ажиллагаа явуулж байгаа зөвшөөрөлтэй байгууллагууддаа шалгалт хийх шаардлага үүссэн юм.

Тэгэхээр энэ дээр бид анхаарч ажиллах шаардлагатай байна гэдгийг хэлмээр байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Батсүмбэрэл: Мэдээлэл танилцуулсан “Монгол Улсын Аялал жуулчлалын холбоо” төрийн бус байгууллагын ерөнхийлөгч С.Баясгалан танд баярлалаа.

Дараагийн мэдээллийг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын газрын дарга В.Батчимэг танилцуулна.

Таныг урьж байна. Микрофоныг нээе.

В.Батчимэг: Сайн байцгаана уу? Дэд хорооны эрхэм гишүүд ээ.

Мөн аялал жуулчлалын салбарын мэргэжлийн холбоод болон бусад холбоодын төлөөлөгч нар ээ,

Өмнө нь хуралдаанаар манай Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны танилцуулгыг хийсний дагуу бид бүгдийн өмнөх дэд хорооноос гарсан саналын дагуу өчигдөр бид Хууль зүйн яаман дээр хил орчмын аялал жуулчлалын эхний дэд хорооноос гарсан саналын дагуу хуралдааныг зохион байгууллаа.

Тэгээд бас энэ дэд хорооноос авч хэрэгжүүлж байгаа ажлын үр дүн эхний байдлаар гарч байна гэдгийг эрхэм гишүүддээ дуулах нь таатай байх аа.

Монголын аялал жуулчлалын салбарыг дэмжих хөнгөлөлттэй зээлийн бодлого гээд 2025 оны 255 дугаар тогтоолоор батлагдсан байгаа.

Та бүхэн өмнөх манай үйл ажиллагаатай танилцахад бид танилцуулсан.

Уг хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн хүрээнд 2026 онд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын багцад 13.0 тэрбум төгрөг батлагдсан.

Энэ нь 2026 онд нийт 180.0 тэрбум төгрөгийн зээл олголт өгөхөөр төлөвлөсөн байсан.

Гэвч аялал жуулчлалын салбарыг дэмжих хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээг 3 тал болон бусад арилжааны 10 банктай хамтарч батлах асуудал маань нэлээдгүй хугацаа алдаж, 1, 2 дугаар сарын хугацааг алдсан учраас бидний 13.0 тэрбум зээлийн дотаци маань нийт 250 тэрбум төгрөг болж өссөн тооцоолол гарсан.

Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахын тулд бид 22 удаагийн өөрчлөлт засварлалыг хийж, Сангийн яам, Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яам, Монголбанк, арилжааны 10 банк 2026 оны 3 сард гэрээг баталлаа.

Хөнгөлөлттэй зээлийн 2026 онд олгох нийт зээлийн хэмжээ харьцангуй бага ч гэрээний талуудтай зээлийн хувь хэмжээг зөвшилцөн аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг сайжруулах, зочид буудал, аялал жуулчлалын цогцолбор, жуулчны бааз, авто зам дагуух түр буудаллах цэгүүд, авто тээврийн хэрэгсэл, агаарын тээврийн хэрэгсэл гэсэн эдгээр 6 бүтээгдэхүүнд хөнгөлөлттэй зээл олгохоор төлөвлөж гэрээнд тусгагдсан.

Арилжааны банкуудад даах эрсдэл, зохистой харилцааг уялдуулан нийт зээлийн 250.0 тэрбум төгрөгийн хуваарилалтыг гэрээнд тусгагдсаны дагуу, гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу Монголбанк хуваарилалтыг тогтоосон. Үүнд.

- Хаан банк 80 тэрбум,
- Худалдаа, хөгжлийн банк 50 тэрбум,
- Голомт банк 49 тэрбум,

- Төрийн банк 15 тэрбум,
- Хас банк 24 тэрбум,
- Капитрон банк 9 тэрбум,
- Тээвэр хөгжлийн банк 6 тэрбум,
- Ариг банк 3 тэрбум,
- Богд банк 6 тэрбум,
- M bank 8 тэрбум – гэсэн хуваарилалт хийгдсэн.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам нь зээл авахыг хүсэж байгаа болон аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа аялал жуулчлалын бүх холбоодоосоо гишүүн байгууллагуудын жагсаалтыг авч нэгтгэж бүх арилжааны банкуудад илгээж ажиллаж байна.

Банкуудад ирсэн зээлийн хүсэлтийг Та бүхэнд танилцуулах юм бол арилжааны банкуудад нийт 250.0 тэрбум төгрөгийн зээлийн хэмжээтэй харьцуулахад одоо ирсэн хүсэлт 9.2 дахин давж, 2 их наяд гарсан байгаа.

Аялал жуулчлалын салбар дахин санхүүжилтийн эрэлт хэрэгцээ байсаар байна.

Жишээ татах юм бол ХААН банканд 80 тэрбумд давсан байна,

- Худалдаа, хөгжлийн банканд 501.0 тэрбум,
- Голомт банканд 221 тэрбум,
- Хас банканд 183 тэрбум,
- Капитрон банканд 40 тэрбум,
- Ариг банканд 51 тэрбум,
- Тээвэр хөгжлийн банк 30 тэрбум,
- M bank 30 тэрбум,
- Богд банк 29 тэрбум,
- Төрийн банк 27 тэрбум –

-гэсэн нийт 2 их наяд төгрөгийн санхүүжилтийн хүсэлт буюу 1053 аж ахуйн нэгжээс ирсэн байгаад байна.

Мөн арилжааны банкуудын шаардлага шалгуур үзүүлэлтийг хангаж 500 сая төгрөгөөс дээш зээл авах шийдвэр гарсан тохиолдолд гэрээний дагуу зээл зориулалтын дагуу зарцуулагдаж байна уу гэдэг Соёл, спорт, аялал жуулчлалын яам хяналтын гэрээ байгуулах үүрэг хүлээсэн.

Үүний дагуу тухайн байгууллагуудтай гэрээ хийсэн тохиолдолд ил тод нийтэд зарлаж мэдээлэх болно.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд 2026 оны 4 сарын 13-ны байдлаарх тоог Та бүхэнд харуулъя.

Одоогоор 337 тэрбум төгрөгийн 157 зээлдэгчийн хүсэлтийг банкууд судлан ажиллаж байна. Үүнээс Улаанбаатар хотод 111 тэрбум төгрөг, 48 зээлдэгч, орон нутгаас нийт 268 тэрбум төгрөгийн 120 зээлдэгч хүсэлт байгаа нь нийт хүсэлтийн дийлэнх хувийг орон нутгийн аж ахуйн нэгжүүд эзэлж байна.

Үүнээс 13 аймгийн хүсэлтийн гаргасан мэдээлэл бидэнд ирсэн байна. Та бүхэн дэлгэцэд харахад бүгдээрээ байж байна.

Өчигдрийн 4 сарын 13-ны байдлаар манай Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд Худалдаа, хөгжлийн банкнаас 9 аж ахуйн нэгжийн 36 тэрбум төгрөгийн зээл олгох шийдвэр ирсэн ба хяналтын гэрээ байгуулах хүсэлт ирүүлээд байна.

Дээрх шийдвэрүүдийг харахад аж ахуйн нэгжүүдийн нэрс нь энэ дээр байж байна. Худалдаа, хөгжлийн банк шийдвэрээ аль хэзээ гаргаад эхэлсэн байна.

Тэгээд нийт 36 тэрбум төгрөгийн зээлийн шийдвэр гаргасан байна.

Үүнд нь бид хяналт хийж үзэх юм бол –

- зочид буудлын зориулалтаар 2 зээлдэгч,
- аялал жуулчлалын цогцолборын зориулалтаар 2 зээлдэгч,
- жуулчны баазын зориулалтаар 3 зээлдэгч,
- авто зам дагуу түр буудаллах үйлчилгээний цогцолборын зориулалтаар 2

-гэсэн тус тус ирүүлсэн байна.

Бусад банкууд нь зээлийн шалгуур шаардлагыг хангаж байгаа асуудал дээр хяналт шалгалтаа хийж, судалж ажиллаж байна гэдгийг 4 сарын 13-ны байдлаар манай яаманд мэдээлэл хүргүүлсэн байна.

Эцэст нь хэлэхэд өнөөдөр Засгийн газрын хуралдаанд манай Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын газар болон манай Соёл, спорт, аялал жуулчлалын сайд Ж.Алдаржавхлан Засгийн газрын хуралдаан дээр зээлийн явцын талаар танилцуулга хийсэн.

Зээлийн танилцуулга хийсний хүрээнд цаашид зээлийг нэмэгдүүлэх асуудал дээр Засгийн газраас хийж хэрэгжүүлэх бодлогын асуудлуудыг дэмжиж ажиллая гэсэн. Судалж эргэж танилцуул гэсэн.

Мөн цаашид 6 жилийг 12 жилийн хугацаанд цаашдаа зээлийг аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулалтын зээлийг үргэлжлүүлж олгох нь зөв юм гэдэг асуудлуудыг бид танилцуулж чиглэл өгсөн байгаа. Баярлалаа.

Н.Батсүмбэрэл: Танилцуулга хийсэн В.Батчимэг даргад талархлаа.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Ванчиндоржийн Батчимэг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын газрын дарга, Төмөрдашийн Баттулга Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны Ерөнхийлөгч, Ванчинхүүгийн Батзориг Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны дэд Ерөнхийлөгч, Маналжавын Нарангэрэл Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны гүйцэтгэх захирал, Сандуйжавын Алтантуяа Жуулчны баазын холбооны тэргүүн, Энхжаргалын Наранхүү Солонгос зах зээлийн холбооны тэргүүн, Батбаярын Ижилмөрөн Жуулчин тээврийн холбооны тэргүүн, Саранжавын Баясгалан “Монгол Улсын Аялал жуулчлалын холбоо” төрийн бус байгууллагын Ерөнхийлөгч, Сундуйн Амгаланбат “One Mongolia Group”-ийн Ерөнхийлөгч, Пүрэвжаргалын Мөнхжаргал “Хүннү Эйр” компанийн захирал, Ганбатын Алтаншагай “Дөрвөн Бэрх” жуулчны баазын захирал, Баттогоогийн Түвшинжаргал “IBIS Styles” зочид буудлын захирал.

Гурван танилцуулгатай холбоотойгоор асуулт асуух гишүүд нэрээ өгье.
Р.Батболд гишүүн.

Р.Батболд: Хүрэлцэн ирсэн Та бүхэнд оройн мэнд хүргэе.

Одоо манай бүх салбарууд дээр л яг ийм зүйл адилхан тохиолдоод байгаа юм. Баахан давхардсан яг адилхан мэргэжлийн холбоод гарч ирээд хоорондоо би эхнийх нь, эсвэл би толгойлоод явах ёстой гэдэг юм уу нэг иймэрхүү асуудал бүх салбар дээр байгаа. Энэ ганцхан аялал жуулчлал дээр ч байгаа юм биш л дээ.

Тэгээд ер нь яах вэ, хамтраад ажиллаад явах боломж байдаггүй юм болов уу гэж би гайхаад байдаг юм. Тийм.

Одоо жишээлэх юм бол Та сая Солонгосынх гэсэн, Та тээврийнх гэсэн. Хоёуланд нь харьяалагдаж явдаг юм уу, эсвэл нэгэнд нь харьяалагдаад явдаг юм уу? Энэ хоёр холбооныхоо.

С.Баясгалан захирлаас асуухад танайх гишүүнчлэл чинь ямар байдаг юм? Хэчнээн гишүүнчлэлтэй яваад байгаа юм? Нөгөө аялал жуулчлалын холбоо чинь ингээд гишүүнчлэлийнхээ тоог тавиад байна шүү дээ.

Тэгээд манайх 891, тэр дотроо 17, 18 холбоод нийлсэн байна гээд байдаг. Танайх ямар байдаг юм? Тийм ээ.

Тэгээд давхардаагүй бол нийлүүлээд аваад явж болдоггүй юм уу? Давхардсан бол яагаад хоёр удирдлага яваад байдаг юм? Аяллын компаниуд байдаг юм уу?

Холбоод нь өөрсдөө яагаад тэрийгээ зөвшөөрөөд байдаг юм гэдэг ийм асуулт эхлээд асуумаар байна.

Тэр зээлтэй холбоотой асуудал. Одоо хэрвээ ингээд хоорондоо алинаар нь дамжуулж явахаа мэдэхгүй бол тэгээд банк нь өөрөө шийдээд явахаас л өөр аргагүй л болох байлгүй дээ.

Тэгээд бодлого нь яаж явах юм байгаа юм. Аль холбоогоороо дамжина гэх юм байхгүй болох гээд байна шүү дээ энэ чинь.

Тэгэхээр нөгөө яам түрүүчийн уулзалт дээр яриад байсан. Бид яг аялал жуулчлалынхаа ямар бодлоготой явах юм бэ гэдэг.

Тэгэхээр холбоод нь өөрсдөө ойлголцохгүй яваад байвал бид ер нь нэг чиг гаргаж чадах юм уу, үгүй юу гэдэг асуудал байгаад байна.

П.Мөнхжаргал захирлаас нэг юм асууя.

Зээл дээр нислэгийн зээл гэсэн юм байсан. Та тэрийг мэдэж байна уу? Ямар зориулалттай, ямар зээл байгаа юм? Та мэдэж байвал хэлээд өгөөрэй.

Тэгээд бас нэг хүсэлт байгаа. Танай “Хүннү” Өмнөговь руу 4 явдаг билүү? 3 явдаг билүү? 4 явж байсан. Тийм ээ. Тэгж байснаа больсон. Уг нь танайхыг яваад өгөөч ээ гэсэн хүсэлтүүд жуулчны компаниудаас ирээд л байдаг юм байна лээ. Тэгэхгүй бол бид жуулчингаа тээвэрлэх юмгүй боллоо. МИАТ нисээд байдаг. МИАТ ерөөсөө хүрэлцээгүй болсон байна гэдэг хүсэлт ирээд байгаа шүү. П.Мөнхжаргал захирал аа. Үүнийг уламжилье. Тийм.

Тэгэхээр энэ харилцан ойлголцох тал дээрээ та нар ямархуу санаа бодолтой байдаг юм бэ? Яам үүнийг яаж авч үзэж байгаа юм? Тэрийгээ хэлж өгөөч.

Н.Батсүмбэрэл: Индрийн микрофон дээрээс хариулна.

Эхлээд С.Баясгалан, тэгээд М.Нарангэрэл, тэгээд П.Мөнхжаргал. Өөр хэн байлаа? В.Батчимэг. Тийм.

Протоколд орох учраас өөрийгөө товчхон нэрээ хэлээд тэгээд явчих.

С.Баясгалан: “Монголын аялал жуулчлалын холбоо”-ны ерөнхийлөгч С.Баясгалан.

Ерөнхийдөө холбоод хамтраад ажиллаад явахад ямар нэгэн асуудал байхгүй. Харин сая хөнгөлөлттэй зээл дээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас, бүх мэргэжлийн холбоодоос ижил тэгш гишүүнчлэлийн нэрс авсан.

Энэ дээр ямар нэгэн ялгаварлах үзэл байгаагүй.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулга дээр аялал жуулчлалын мэргэжлийн холбоо гэж байна. Энэ нь нийтийн эрх зүйт хуулийн этгээд байна. Энэ нь төрийн бүх чиг үүргийг хэрэгжүүлнэ гээд эдийн засгийн бусад бүх салбарт байхгүй нэг зохицуулалтыг энэ хуульд хийсэн байгаа юм.

Тийм болохоор энэ хуулиа дагаад, дээрээс нь дахиад Засгийн газрын нэг тогтоол гарсан байгаа юм.

2023 оны 10 сарын 04-ний өдрийн 370 дугаар тогтоолоор “төрийн зарим чиг үүргийг Төрийн бус байгууллагад гүйцэтгүүлнэ” гээд. Энэ дээр аялал жуулчлалын мэргэжлийн холбоонд энэ бүх чиг үүргийг хэрэгжүүлнэ гээд энэ тогтоолоос хойш 3-аас 4 жилийн хугацаанд аялал жуулчлалын салбарын бүх л төрийн чиг үүрэг нэг холбоогоор явж байгаа.

Энэ бол бид ойлголцохгүйдээ биш, бид гишүүдийнхээ эрх ашгийг, бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах ёстой.

Тэгээд энэ дээр ийм байдал үүссэн байгаа.

Ерөнхийдөө Мэргэжлийн нэгдсэн холбоодын тухай хууль дээр тухайн эдийн засгийн салбарт өөрийн гэсэн “аж ахуйн нэгж, хувь иргэн, төрийн бус байгууллагуудаас бүртгэлтэй бүх холбоодыг мэргэжлийн холбоод гэнэ” гэж байгаа.

Тэгэхээр ер нь цаашдаа мэргэжлийн холбоодыг үүсгэхдээ аль нь “мэргэжлийн холбоод” юм, харин л аль нь “мэргэжлийн нэгдсэн холбоод” юм гэдэг ялгааг үүсгэхгүй бол энэ хуулийг угтаад “мэргэжлийн холбоо” гэдэг нэр өгсөн нь мэргэжлийн холбоо шиг харагдаад, бусад нь гишүүнчлэлтэй нь мэргэжлийн холбоо биш юм шиг харагдаад байгаа нөхцөл байдал ажиглагдаж байгаа.

Монголын аялал жуулчлалын холбооны хувьд 300-аас 400 орчим гишүүнчлэлтэй байна. 300 гаруй гишүүнчлэлтэй байна.

Тэгээд энэ хуулийн заалтыг Та бүхэнд бид одоогийн үүссэн нөхцөл байдал болон эрх зүйн орчны бүх тайлбарыг бид аваад ирсэн байгаа.

Тэгээд Та бүхэнд тараагаад үзүүлье гэсэн саналтай байна.

Тэгээд хамгийн гол нь ерөнхийдөө нэг холбоонд эрхийг олгохдоо ямар нэгэн сонгон шалгаруулалт байхгүй.

Тэгээд энэ дээр нэг асуудал байгаа. “Нийтийн эрх зүйт хуулийн этгээд” гэдэг нэг ийм статусыг гаргаад ирсэн. Энэ нь ямар ч хууль ч тайлбарлаж

чаддаггүй. Засгийн газрын тогтоол дээрээ болохоор “төрийн бус байгууллага” гээд орсон.

Тэгэхээр нийтийн эрх зүйд хуулийн этгээд нь төрийн байгууллага юм гэдэг юм яриад байдаг. Дахиад түрүүн хэлсэнчлэн “Аялал жуулчлалын хөгжлийн төв” гээд яамны харьяанд байсан төрийн байгууллагыг энэ холбоо бий болсонтой л хамтатгаад татан буулгасан.

Тэгээд тэр байгууллагын нэр, гадаад тамга тэмдэг, вебсайтыг ямар нэгэн шийдвэргүй аваад ашигласан байгаа.

Тэгэхээр гадааддаа болохоор энэ бол төрийн байгууллагын статус буюу **Mongolian Tourism Organization** гээд, ингээд нөгөө **association** биш юм шиг, NGO (Non-Governmental Organization) биш юм шиг ийм төөрөгдлийг бий болгоод байгаа.

Тэгэхээр энэ дээр ийм тайлбар хэлмээр байна. Баярлалаа.

Н.Батсүмбэрэл: М.Нарангэрэл. Индрийн микрофон дээрээс.

М.Нарангэрэл: С.Баясгалын Ерөнхийлөгчид тайлбар хэлье.

Аялал жуулчлалын тухай хууль 2022 оны шинэчилсэн найруулгыг хийх ажлын хэсэгт Монголын аялал жуулчлалын холбооны ерөнхийлөгч Д.Гантөмөр тухайн үед, одоогийн байгаа Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны дэд ерөнхийлөгч Д.Амгаланбат, Монголын аялал жуулчлалын холбооны бусад төлөөллүүд хуулийг батлах ажлын хэсэгт орж ажилласан байгаа.

Шаардлагатай бол бид энэ ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг бид хороонд хүргүүлж болно.

“Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” гэдэг нэрийг яг өгч байх явцад манай Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны ахлах зөвлөх бид яг энэ хэлэлцүүлгийн үед байж байсан.

Бид анхнаасаа энэ нэрийг төөрөгдүүлсэн нэр, бусад байгууллагын нэртэй давхацсан эрсдэл үүсэж байна гэсэн.

Тэгэхээр цаанаасаа “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” гэдэг нэрийг олгох нь зүйтэй гэж тухайн үеийн хууль санаачлагч нар үзсэн учраас энэ нэрийг тавьсан.

Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны нэршлийн хувьд Монголын аялал жуулчлалын холбоо Аялал жуулчлалын мэргэжлийн холбоог шүүхэд өгсөн. Захиргааны хэргийн.

Анхан болон давж заалдах шатын шүүхээр Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны нэр ямарваа нэгэн байдлаар. Тийм тийм.

Н.Батсүмбэрэл: Р.Батболд гишүүн микрофоноо.

Р.Батболд: Би түрүүн асуух гэж байсан асуултдаа нэг зүйл мартсан байна.

Одоо нөгөө Татварын багц хуулийн шинэчлэл яв асуудал явагдаад байгаа шүү дээ. Энэ дээр уг нь татварын ажлын хэсэг бас мэргэжлийн холбоодтай, яамтай хэлэлцүүлэг хийгээд байсан. Түүн дээр ирж оролцсон хүмүүс байгаа юу? Танайхаас байгаа юу? Тийм ээ.

Нөгөө давхар татвар аваад байгаа, гадагшаа экспортоос 20 хувь аваад байгаа энэ тэрээ ер нь тэнд ярьсан юм уу? Та хэд. Ярьсан уу? Тийм ээ. Саналаа өгсөн байгаа юу? Тийм ээ. Л.Соронзонболд гишүүнд өгсөн үү.

Н.Батсүмбэрэл: В.Батчимэг дарга индэр дээр хариулъя.

В.Батчимэг: Р.Батболд гишүүний асуултад хариулъя.

Манай бүхий л аялал жуулчлалын салбарын нүүр царай болсон компанийн удирдлагууд, мэргэжлийн холбоодын удирдлагууд байна.

Миний бие аялал жуулчлалын салбарт 12 дахь жилдээ ажиллаж байна.

Нийслэлийн анхан шатаас эхэлж ажилласан. С.Баясгалан даргыг газрын дарга байхад би цэрэг нь болж ажиллаж байсан ийм хүн байгаа.

Манай салбар Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, Монголын аялал жуулчлалын холбоо л гээд байгаа юм.

Ер нь холбооны хүрээнд 300-аад холбоо байгаа.

Тэгэхээр бүгдтэй нь бид хамтарч ажиллаж байгаа. Мэдээж бид төрийн албан хаагч хүн. Би төрийн албанд 10... /минут дуусав/

Н.Батсүмбэрэл: Гүйцээж хариулъя. Индрийн микрофоныг нээе.

В.Батчимэг: Төрийн албанд 18 жил ажиллаж байна. Анхан шатаас ажилласан хүн. Хуулиа хэрэгжүүлж ажиллаж байгаа. Аялал жуулчлалын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа.

Би өмнө нь мэдээлэл хийхэд Аялал жуулчлалын тухай хууль 2023 онд шинэчлэн батлагдсан. Хууль дагаж гарах 7 журам байх ёстой. 6-г нь батлуулчаад ингэж ярьж байна. Ингэж л ажиллаж байгаа.

Би бүх салбарынхантайгаа хамтарч ажилладаг. Өнөөдөр манай салбарын амжилт өнөөдөр бүгд энэ хүмүүсийн хүч хөдөлмөр байсан. Тийм л хариултыг хэлье дээ. Баярлалаа.

Н.Батсүмбэрэл: Таныг урьж байна. П.Мөнхжаргал захирал. Индрийн микрофоноо нээе.

П.Мөнхжаргал: Сайн байцаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Эхлээд зээлийн асуудлыг ярья. Агаарын тээвэр дээр 12.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл тавигдсан байгаа. 3.4 сая доллар. Ер нь их бага мөнгө. Агаарын хөлөг худалдаж авахад энэ үндсэндээ.

Одоо зах зээл дээр 8 хүний засвар худалдаа **Cessna 208** гэдэг онгоц 4 сая доллар байгаа. Бид сая нэгийг авсан.

Үндсэндээ агаарын тээвэр аялал жуулчлалтай юугаар холбогдоод байгаа юм гэвэл бид эд нарыг үнэтэй болгоод байгаа юм. Яагаад гэвэл бидний зардал өндөр учраас бид жуулчдад үнэтэй үнэ санал болохоор эд нар биднийг үнэтэй байна, үнэтэй байна л гээд байдаг.

Бид онгоцыг 20 хувийн хүүтэй авч байгаа юм чинь үнэтэй байхаас яах вэ. 20 хувийн хүүтэй банкны арилжааны зээлээр авч байгаа. Өөр арга байхгүй байгаа.

Орон нутгийн нислэг өөрөө нэлээн онцлогтой.

Р.Батболд гишүүнд тайлбар хэлэхээс өмнө жижигхэн юм хэлэхгүй бол. Орон нутгийн нислэг ерөөсөө аягүй онцлогтой. Бид их хүн цөөтэй. Дээрээс нь... /минут дуусав/

Н.Батсүмбэрэл: Гүйцээж хариулъя. Индрийн микрофон нээе.

П.Мөнхжаргал: Дээрээс нь газар нутаг том учраас манай зардал дандаа их гараад байдаг.

Манай орон нутгийн нислэгийн 85 хувь нь Улаанбаатар, Оюу Толгойн зорчигч. 15 хувь нь л бусад нислэг байгаад байдаг.

Тэгээд хамгийн олон хүн явдаг Улаанбаатараас жишээлбэл Ховд явдаг чиглэл гэхэд л жилдээ 15-аас 20 мянган зорчигч л явж байгаа. Ийм цөөн зорчигчтой байгаа юм.

Тэгээд МИАТ компани 2004 онд орон нутгийн нислэгээс гараад хувийн хэвшлийнхэн орон нутгийн нислэгийг янз янзын аргаар хийгээд, өөр өөрсдийнхөө боломжоороо явуулж байсан.

Гэхдээ 2024 онд Засгийн газраас шийдвэр гаргаад МИАТ компанийг оруулсан. МИАТ компани ард түмэндээ үйлчлэх хямд үнэтэй бодлого гаргана гээд МИАТ компани үндсэндээ орон нутагт шинээр **CRJ-700** (Bombardier) гэж 70 хүнээс худалдаа онгоц оруулж ирээд нислэг үйлдэж эхэлснээс хойш хажуугаар нь хувийн хэвшлийнхэн нисэхээ больсон. Нисэх боломжгүй болсон. Маш хямд зардал гаргасан.

Тэр хямд үнийнхээ өртгийг эхний жилдээ... /минут дуусав/

Н.Батсүмбэрэл: Гүйцээж хариулъя. 1 минут сунгая.

П.Мөнхжаргал: Дараагийн жилүүдээс эхлээд МИАТ компани бусад нислэгүүдийнхээ орлогоор үүнийг санхүүжүүлээд хаагаад явж байгаа.

Миний ойлголсон ойлголтоор жилдээ 10-аас 20 тэрбум төгрөгийн алдагдал гардаг гэсэн байгаа.

Даланзадгадын хувьд бид энэ жил зурвас зассан. Нэг олон улсын нислэг хийх гээд хөөцөлдөөд байгаа юм.

- ➔ Японоос ямар ч гэсэн 1-ээс 2 нислэг хийнэ.
- ➔ Бээжингээс нислэг хийх асуудлууд яригдаж байна.
- ➔ Солонгосоос энэ жил 6 нислэг хийнэ гэсэн төлөвлөгөөтэй байгаа.

Уг нь орон нутагт нислэг хийвэл Улаанбаатараар дамжихгүй сонирхол байгаа. Хүмүүс байгаа юм. Орон нутаг үнэтэйдээд байгаа юм. Орон нутгийн нислэг Солонгосоос Улаанбаатарт буух нь Солонгосоос Даланзадгад буух нь хамаагүй үнэтэй болоод байгаа юм. Шатахуун нь Улаанбаатараас газраар очиж байгаа. Тэгээд аймагт бүх юм нь үнэтэй болчихоод.

Уг нь үүнийг ямар нэг хэмжээгээр төрөөс дэмжээд, хөнгөлөлт олговол энэ нислэг яваад байх юм бол цааш цаашдаа ядаж зуны улиралдаа хэрэгтэй байгаа юм.

Ер нь бид агаарын тээвэр гээд энд хэлэхэд дэлхийг хараад байхад агаарын тээвэр дотацгүйгээр явахгүй байна. Бүгд... /минут дуусав/

Н.Батсүмбэрэл: Р.Батболд гишүүн тодруулах уу? Р.Батболд гишүүн тодруулъя.

Р.Батболд: Тийм. Бүгдийнх нь зовлон яг тэр болоод байгаа юм.

Агаарын тээвэр чинь өөрөө үнэтэй болоод наашаа жуулчин татахад аягүй хэцүү болоод байгаа юм л даа.

П.Мөнхжаргал захирлын хэлээд байгаа үнэн л дээ. Ер нь улсууд дотоодын нислэгтэй байдаг юм уу. Тийм ээ. Яг жуулчны зориулалтаар явж байгаа тэр чартерууд байдаг юм уу, түүндээ ер нь байнгын дотаци өгөөд явдаг юм билээ л дээ.

Тэгээд улам хэцүү болоод байна. Яах вэ гэдэг. Энэ жилийн хувьд аягүй сонин асуудал болж байгаа. Би бараг долоо хоногийн өмнө үзсэн. Америкаас Улаанбаатарт буучхаад буцаад нисэхэд Korea Air 15 мянган долларын үнэ өгч байна лээ. 7 сард гээд өгөхөд. Одоо 7 сард гээд захиалахад. Ийм байдалтай байхад бид яаж явах юм бэ гэдэг их хүндрэлтэй асуудал байгаа юм.

Тэгэхээр нислэгийн асуудал дээр бид дотацийн асуудлыг бодох л ёстой юм билээ гэдэг. Түүн дээр санал нэг байгаа.

Н.Батсүмбэрэл: М.Энхцэцэг гишүүн асуултаа асууя.

М.Энхцэцэг: Танилцуулга хийсэн Аялал жуулчлалын мэргэжлийн холбоодод баярлалаа.

Тэгэхээр хэд хэдэн асуулт байна л даа.

▷ **Нэгдүгээрт**, хамгийн том хамгийн чухал сонирхол татаж байгаа асуулт болохоор мэдээж аялал жуулчлалын компаниудад өгч байгаа 6 хувийн хүүтэй зээлийн асуудал.

Тэгэхээр 6 хувийн хүүтэй 6 жилийн хугацаатай ийм бүр олдошгүй ховор зээлийг авах аялал жуулчлалын компаниудын эрэлт хэрэгцээ маш их байгаа гэдэг нь сая хүсэлтээс харагдаж байна л даа.

Тэгэхээр чухам ямар шаардлагыг ямар азтай компаниуд нь энэ зээлийг олж аваад байна аа?

Тэгэхээр саяын шалгаруулсан байгаа гээд Худалдаа, хөгжлийн банкнаас 9 байгууллагад өгсөн гэж байна л даа.

Тэгэхээр энэ 9 байгууллагын дэлгэрэнгүй танилцуулгыг ирүүлээч ээ. Яг ямар зориулалтаар хэн хэн яаж авчав аа? Яагаад гэхээр бод л доо. Маш олон компаниудаас аз нь шовойсон хэд л авсан байна шүү дээ.

Тэгэхээр тэр аз нь шовойсон хэд чинь үнэхээр бидний зорилгыг биелүүлж, үнэхээр Монгол Улсын аялал жуулчлалыг шинэ түвшинд гаргах яг тэр зорилгоор авч чадаж байна уу гэдгийг бид хармаар, шалгамаармаар, үзмээр байгаа байхгүй юу. Нэгдүгээрт.

▷ **Хоёрдугаарт**, хөдөө орон нутагт зээл өгөх санхүүжилт нь дууссан гэж ярьж байна.

Тэр яг ямар учиртай юм бэ? Яагаад гэхээр аялал жуулчлал чинь хөдөө орон нутагт л хөгжих ёстой шүү дээ. Тэнд очиход нэг аятайхан буудал, аятайхан тог цахилгаантай, жорлонтой аялал жуулчлалын тэр кемпүүд чинь хөдөө орон нутагт л байх ёстой шүү дээ.

Тэгэхээр саяын авсан байгууллагууд чинь чухам аль аймагт байгаад байна аа? Зөвхөн хотод байгаа хэдэн компаниуд аваад байна уу? Хэдэн том монопол компаниуд чинь авчхаад байна уу?

Тэгэхээр бидний эцсийн зорилго аялал жуулчлалын энэ зээлээр чинь энэ аялал жуулчлалын салбарыг шинэ шатанд гаргах. Тэгэхийн тулд бид мэдээж энэ зээлийн хүртээмжийг сайжруулах хэрэгтэй. Аль болох л олон хүнд. Тэгээд дээрээс нь үр дүнд хүрсэн ийм ажилд зарцуулах хэрэгтэй. Энэ асуудлыг асуумаар байна.

Хоёрдугаарт нь, тэр нэг төрийн бус байгууллага. Аялал жуулчлалын салбарт нийтдээ хэдэн төрийн бус байгууллага байдаг юм?

Хоёрдугаарт нь, сая улсын нэрийг бариад нэг төрийн бус байгууллаа гээд тэгж ярьж байна.

Тэгэхээр тэрийг засахын тулд яг юу хийх ёстой юм гэдгийг Та нар бидэнд хэлээч ээ. Ямар хууль дээр өөрчлөлт оруулах ёстой юм? Танай шинэ аялал жуулчлалын сайд чинь хамгийн түрүүнд хийх ёстой ажил чинь бараг тэр юм биш үү?

Тэгээд дээрээс нь тэр нэг 10 тэрбум ярих шиг боллоо. Өөрөөр хэлбэл нэг ийм төрийн бус байгууллагыг хүчээр байгуулангуутаа улсын 10 тэрбумыг авч байгаа гэх шиг болсон. Тэрийг тодруулаач ээ?

Дээрээс нь аялал жуулчлал, энэ төрийн бус байгууллага чинь төрийн зарим үйлчилгээг үзүүлж байгаа юм гэхээр яг ямар үйлчилгээг үзүүлээд байгаа юм бэ? Тэрийг тодруулж хэлж өгөөч ээ.

Тэгээд дараагийн асуудал болохоор ер нь төрийн бус байгууллагыг ил тод байлгах. Дээрээс нь цаанаа олон компаниудад үйлчилгээ үзүүлэх.

Тэгэхээр чухам ямар үйлчилгээ тэр аялал жуулчлалын компаниудад үзүүлээд байгаа юм? Тэрний татвар нь хэд байдаг юм?

Тэгээд одоо танай төрийн бус байгуулаагүй, ороогүй хүн бол тэр зээлийг бол авахгүй л юм шиг байгаа юм.

Н.Батсүмбэрэл: Хариулах хүмүүс индэр дээр очъё.

Өөрийгөө танилцуулаад тэгээд хариулна. Индрийн микрофон нээе.

В.Батчимэг: М.Энхцэцэг гишүүний асуултад хариулъя.

Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын газрын дарга В.Батчимэг.

Зээлтэй холбоотой нэлээдгүй асуудал гарч байна. Яалт ч үгүй маш их эрэлт хэрэгцээ байсан. Аялал жуулчлалын салбар нь хөгжихийнхээ хэрээр аж ахуйн нэгжүүд маань эрвийх дэрвийхээрээ сайжруулах нь сайжруулаад, ор хоногоо нэмэгдүүлэх санаа сэтгэгдэл байх шиг байна.

Бидний хөнжлийн хэмжээ 250 тэрбум төгрөг. Одоо даваад ирсэн. Сая PPT дээр байсан. 2 их наяд гарчхаад байгаа.

Үүнийг бид яах вэ гэхэд цаашид дараа дараагийн шатны арга хэмжээг авахгүй бол үнэхээр хэрэгцээ шаардлага дуусахгүй байна.

Бид анх 12 төрөл дээр аялал жуулчлалын зээлийг олгоно гэж байсан. Гэтэл бид бас ч үгүй бас яг нэн шаардлагатай буюу дэд бүтэц, орны тоог, энэ олон сая жуулчныг авахын тулд бидэнд юу нэн тэргүүн шаардлагатай байгаа вэ гэхэд бид ор хоногийг сайжруулах, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх гэдэг асуудлын хүрээнд—

- зочид буудал,
- жуулчны бааз,
- аялал жуулчлалын цогцолбор –

-гэсэн 3 байршуулах хэрэгсэл дээр авч үзсэн.

Мөн бид нолийн асуудал шаардлагатай учраас зам дагуух түр буудлага буюу 2024 оны Засгийн газрын 189 дүгээр тогтоолоор батлагдсан 58 газрын зам дагуух түр буудуулах цэгүүд дээр бид зээлийн асуудлаар хөрөнгө оруулалтын дэмжлэгийг үзүүлж, нолийн асуудлаа дэмжье гэдэг ийм асуудлуудыг бид дэвшүүлсэн.

Мөн бидний хамгийн нэн тэргүүнд шаардлагатай авиа компаниуд дээр онгоц авч өгч чаддаггүй юм гэхэд түрээсийн мөнгө төгрөг, сайжруулах, тэр онгоцоо засварлах гээд 12 тэрбум төгрөгийн, 250-ыг бид Монголбанкттай харилцан тохиролцож байж хуваарилалтыг хийсэн юм.

Тэгээд бид өнөөдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулсан учраас цааш цаашдаа арга хэмжээг авна гэдэгт миний бие итгэж байна.

Тэгээд Монгол Улсын аялал жуулчлалын салбарт 300-аад төрийн бус байгууллага байгаа гэдгийг би дараа нь танд хэрэгтэй гэвэл би танд тэр жагсаалтыг ирүүлж болж байна.

Мөн сая сайд маань наашаа ирэхийн өмнө уулзалт хийсэн. Ирэх долоо хоногт банкуудын төлөөлөлтэй уулзаж зээлийн явцын талаар банкуудын удирдлагуудын төлөөллүүдтэй уулзаж явцын талаар мэдээлэл авъя гэсэн.

Мөн 500 саяас дээш төгрөгийн зээл авахаар болсон тохиолдолд Соёл, спорт, аялал жуулчлалын яам тухайн аж ахуйн нэгжтэй хяналтын гэрээ байгуулах юм.

Ингэснээр зээл зөв зохистой зарцуулагдаж байна уу, аялал жуулчлалын салбарт яг тэр зочид буудал дээр нь байна уу, жуулчны баазын орох хоногийг нэмэгдүүлж байна уу гэдгийг бид хяналтын гэрээгээр харах байгаа юм.

Энэ хяналтын гэрээ хийсэн аж ахуйн нэгжүүдээ бид нээлттэй байршуулж ажиллана гэдгээ олон нийтэд мэдээлсэн болно. Баярлалаа.

Н.Батсүмбэрэл: М.Энхцэцэг гишүүн нэмж тодруулъя.

М.Энхцэцэг: Тэр бусад асуултууд дээр. Тийм ээ.

Н.Батсүмбэрэл: Индрийн микрофон нээе.

С.Амгаланбат: Сайн байна уу? Намайг С.Амгаланбат гэдэг.

М.Энхцэцэг гишүүний асуултад хариулъя.

Ер нь төрийн бус байгууллагууд асуудал үүсгээд. Үүнийг ер нь яах ёстой юм бэ гэж. Тийм ээ.

Түрүүн хэлсэн. 2023 онд Аялал жуулчлалын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа 26 дугаар зүйл буюу аялал жуулчлалын мэргэжлийн холбоо байгуулна гэж оруулаад.

Уг нь хуулиараа бид аялал жуулчлал бол 200, 300 ч холбоо байгаа. Тэгэхдээ яг нэгийг нь онцлоод ингэсэн нь өөрөө эргээд энэ татвар төлөгчдийн мөнгө 10, 20 тэрбумаараа нэг холбоогоор дамжих хяналт ямар байна. Тийм ээ.

Тэгтэл олон улсад. Би Та бүхэнд материал бэлдээд ирсэн. Үзүүлье.

Аялал жуулчлал хөгжсөн Тайланд, Солонгос, Япон, Төв Азийн Казак, Узбек бүгдээрээ аялал жуулчлалын сурталчилгаагаа хэрэгжүүлдэг агентлаг гэдэг юм уу, төрийн байгууллагууд нь хэрэгжүүлээд явдаг.

Зарцуулалтыг харин төрийн бус байгууллагууд, нөгөө тендер, сонгон шалгаруулалтаараа гэдэг юм уу тэр гадаад сурталчилгаа юмнууд дээр нь оролцоод явдаг.

Яг үндсэн... /минут дуусав/

Н.Батсүмбэрэл: Гүйцээж яриулъя. 1 минутад багтаагаарай.

С.Амгаланбат: Үндсэн бодлого чиглэлээ төрийн байгууллагууд юм уу, эсвэл агентлагаараа дамжуулаад хийгээд явдаг гэсэн ийм юутай.

Энэ хүрээнд ч гэсэн би өөрөө бас нэг хохироод л гэдэг юм уу, явж байгаа аялал жуулчлалын бизнес эрхлэгч.

Би жуулчны бааз, аялал жуулчлалын чиглэлийн 6, 7 компанитай. Бүгдэд нь гишүүн. Хуулийнхаа дагуу дахиад би энэ 26.1 дээр заасан байгууллагад бүртгүүлээд 1 сая 200 мянган төгрөгөөр бүртгүүлж байж гишүүн болох ёстой гэдэг юутай. Би 6, 7 компаниар жилд юу гэдэг юм 5, 6 сая төгрөг заавал ч үгүй гишүүн болохын тулд бүртгүүлэх ёстой.

Тэгтэл нөгөө талдаа Н.Учрал Ерөнхий сайдын санаачлаад явж байгаа “ЧӨЛӨӨЛЬЕ” аян гээд зөвшөөрөлгүй, тусгай зөвшөөрөлгүй болгоё гээд яваад байдаг.

Гэтэл нөгөө талдаа энэ ингээд тусгай зөвшөөрөл нь үгээ өөрчлөөд гэдэг юм уу, бүртгүүлэх гэдэг нэрээр ингээд яваад байгааг. Үүнийг л нэн тэргүүнд засах ёстой. Би Та бүхэнд олон улсад байдаг энэ жишгийг, олон улсын хуулиуд ямар байдаг талаар товч мэдээлэл бүрдүүлж ирснээ өгье.

Н.Батсүмбэрэл: 1 минутад багтаагаад. 1 минут сунгая.

С.Амгаланбат: Дээрээс нь өнгөрсөн хугацаанд. Түрүүн С.Баясгалан ерөнхийлөгч хэлсэн.

Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо манай Аялал жуулчлалын яамнаас аваад зарцуулсан төсөв мөнгө хэд зарцуулдаг гэсэн энэ мэдээллийг нь хуулбаруудыг нь аваад ирсэн юм байна.

Үүнийг шаардлагатай бол М.Энхцэцэг гишүүнд хариултын нэмэлт болгоод өгье гэж бодож байна.

Н.Батсүмбэрэл: М.Энхцэцэг гишүүн нэмж тодруулъя.

М.Энхцэцэг: Тэгэхээр асуусан шүү дээ. Тийм ээ. Хуулиар нэг төрийн бус байгууллагыг хүчээр байгуулсан юм байна.

Тэгээд тэр төрийн бус байгууллага нь 10 тэрбум төгрөгийг Соёлын яамнаас авдаг юм байна гэж хэлэх шиг болсон. Тэрийг тодруулаач.

Дээрээс нь тэр төрийн бус байгууллага чинь төрийн яам гүйцэтгэх ёстой яг ямар ямар ажлуудыг хийж өгчхөөд тэр 10 тэрбумыг яамнаас авдаг юм бэ? Тэрийг тайлбарлаж өгөөч ээ. Тэрийг би асуусан. Мэдэхгүй хэнээс асуух юм? Хэн нь хариулах юм? Бодвол яам л байлгүй дээ. Ямар учиртай юм бол? Гайхалтай л юм байна.

Н.Батсүмбэрэл: Индрийн микрофон нээе.

Т.Баттулга: Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны ерөнхийлөгч Т.Баттулга.

Ер нь одоо энэ Аялал жуулчлалын хөгжлийн дэд хорооны хурлын хэлэлцэх асуудлын сэдэв бол аялал жуулчлалын салбарын тэр холбоо ингэж байна, ингэсэн ийм хэрүүлийн сэдэв байх ёсгүй л гэж бодож байна л даа.

Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны явуулж байгаа үйл ажиллагаа бол яг Монгол Улсын.

Түрүүн танилцуулга дээр маш тодорхой дурдсан. Хуулиар хүлээсэн үүргүүд нь тэр аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудыг бүртгэх, Монгол Улсын нийтлэг аялал жуулчлалын сурталчилгаа хийх, мэргэжилтэй болгосон хүний чадавхыг сайжруулах гэх мэтчилэн маш олон нийтлэг үйл ажиллагаа явуулж байгаа.

Энд энэ Монголын аялал жуулчлалын холбооны гишүүд бүгдээрээ бүртгэгдээд, оролцоод, үр шимийг нь хүртээд явж байгаа.

Энэ дээр бидний ярих асуудал бол ер нь аялал жуулчлалын салбарынхаа зорилго, тэгээд нийтлэг сорилтуудаа хэрхэн шийдвэрлэх вэ гэдэг асуудлыг ярьж байна.

Тэгээд бид тодорхой асуудлуудыг энэ дээр танилцуулсан. Түүн дээр Аялал жуулчлалын холбооноос танилцуулсан асуудлууд бас нийтлэг.

Тэгэхээр бид холбооны хувьд хэнтэй ч... /минут дуусав/

Н.Батсүмбэрэл: 1 минут сунгая.

Т.Баттулга: Тэгэхээр энэ аялал жуулчлалын холбооны гишүүд бүгдээрээ үр шимийг нь хамтраад хүрдэг нэг тийм л орчныг бий болгох.

Түрүүн тэнд ярьсан. Монгол Улсад 300 гаруй салбарын холбоо ажиллаад явж байгаа.

Тэгээд ер нь хэнд нь төрийн зарим чиг үүргийг өгөөд явах вэ гэдэг асуудал аяндаа энэ Аялал жуулчлалын хууль хэлэлцэж байхад гарахад бүгдээрээ

хэлэлцээд дундаасаа энэ байгууллагыг байгуул гэдэг зарчмаар л байгуулагдаад явсан.

Тэгээд энд байгаа нөхдүүд бүгдээрээ тэр хуралд нь оролцоод, байгуулаад, гишүүн болоод яваад тэгээд дахиад тусад нь нэг холбоо бид өрсөлдөж байна гээд байдаг. Би хэнтэй ч өрсөлдөөгүй. Бид яг нийтлэг нэг л асуудлынхаа, нэг л зорилгын төлөө ингээд л явж байгаа юм.

Тэр 10 тэрбум гэдэг асуудал ярьж байна. 10 тэрбум гэдгийг би ч бас мэдэхгүй байна. Ерөнхий дүнд нь гарна. Маш нарийн дэлгэрэнгүй тайланг гишүүдэд бид хүргүүлье.

Сүүлийн 4 жилийн хугацаанд Байгаль орчин, аялал, жуулчлалын яам, дараа нь Соёл, спорт, аялал жуулчлалын яамтай манай холбоо яг тэр хуульд заасны дагуу гэрээ байгуулаад. Ер нь дийлэнх хэсэг нь Монгол Улсыг гадаад зах зээл дээр суртчлах, эвент зохион байгуулах гэх мэтчилэн ажлууд дээр жилд ойролцоогоор 1.5-аас 2.5 тэрбум... /минут дуусав/

Н.Батсүмбэрэл: Б.Тулга гишүүн асуултаа асууя.

Б.Тулга: Тийм тийм. Ер нь Байнгын хороон дээр нь шинэ Их Хурлын даргаас асуугаад байгаа юм л даа. Дэгтэй холбоотой.

Асуулт авч хариулт авдаг юм их хангалтгүй байгаа юм. Хэдүүлээ энэ дэгийг жоохон өөрчилмөөр юм билээ. Тэгэхгүй болохоор яг бүтэн хариулж болдоггүй. 1 минутад багтаад. Тийм ээ.

Та бүгдийнхээ энэ оройн амгаланг эрье. Би уг нь эхнээс нь орьё гэж бодсон. Чадсангүй. Уучлаарай. Хурал давхцаад.

Тэгээд манай аялал жуулчлалын холбоодын төлөөлөл ирж тулгамдаж байгаа асуудлуудаа ярьж байгаа гэж ойлгосон.

Тэгээд яамнаас төлөөлөл байгаа юм байна. В.Батчимэг дарга хаана байна? Та юу. Тийм ээ.

Сая хуулийн талаар ярьж байна.

Ер нь манай аялал жуулчлалын хууль их аятайхан хууль болсон гэж би ойлгодог шүү дээ. Манай төрийн бус байгууллагууд, Байгаль орчин, аялал, жуулчлалын яаман дээр байхад нэлээн ажиллаж байгаад их аятайхан хууль гаргалаа гэж тухайн үедээ нэлээн яригдаж байсан ийм хууль.

Тэгээд хэрэгжилт дээр хэдүүлээ аягүй сайн анхаарах ёстой.

Л.Оюун-Эрдэнийн өмнөх Засгийн газрын үед гадаад сурталчилгаа, жуулчдыг татах, жуулчдын өссөн үзүүлэлт, статистик тоо гээд энэ чамлахааргүй сайн үзүүлэлтүүд гарч явж байгаа.

Тэгэхээр энэ эерэг хандлага, трендийг буулгахгүй ажиллах нь Засгийн газрын ч тэр, Их Хурлын, манай төрийн бус байгууллагуудын гол анхаарах зорилт болов уу гэж харж байгаа.

Тэгэхээр Та бүгдээс, энэ төрийн бус байгууллагуудаас асуух асуулт байна. Шинэ Ерөнхий сайд Н.Учрал “ЧӨЛӨӨЛБЕ” санаачилгыг хэрэгжүүлсэн байгаа. Энэ хүрээнд аялал жуулчлалын тээврийн салбарт явдаг хязгаарлалт, дүрэм журмаа тодорхой харж үзээч ээ гэдэг санаачилга явж байгаа юм байна лээ.

Гэх мэтчилэн бусад холбоод дээр яг ингэж тулгамдсан, Та бүгдийн анхааралд, Засгийн анхааралд хүрээд шийдвэр гаргуулахаар ямар ямар санал байна.

Үүнийг миний өмнө асуугаад хэлсэн бол би протокол үзье. Хэрвээ хэлээгүй бол Та бүхэн минь ёстой нэг нэг өгүүлбэрээр энэ дээр микрофон дээр хэлээд протоколд үлдээж өгөөч ээ гэж хүсэж байна.

Хоёрдугаарт, банкны зээлийн асуудал, хөнгөлөлттэй зээл олгох асуудал яагаад удаашралтай байгаад байна? Энэ дээр манай яам хариулаач.

Ноднин баталж өгөөд, төсвийг нь бараг бүтэн хэрэглэж чадсангүй юу? Буцсан уу, яасан бэ? Шийдвэр гараад байдаг. Хэрэгжүүлэлт дээр бид аягүй их алдаад байна. Юун дээр анхаарах вэ гэдгийг одоо манай хариуцаж байгаа яамны газрын дарга хэлбэл маш сайн байна.

Гуравдугаарт нь, Та бүхэн үг хэлэхдээ өвлийн аялал жуулчлал дээр юу анхаармаар байна аа? Бид аялал жуулчлалын салбарыг бүтэн 4 улирлын турш тогтвортой ажиллах нөхцөлийг л хэдүүлээ зорих ёстой.

Манай улс өөрөө онцлогтой. Азийн орон улс орнууд дотор өвлийн аялал жуулчлалыг онцгой хөгжүүлэхэд хамгийн потенциалтай улсуудын нэг.

Тийм учраас энэ дээр юу анхаармаар байна? Бид Л.Оюун-Эрдэнэ Засгийн газар дээр байхад эрчим хүчний хөнгөлөлт гээд л янз янзын хэлбэрээр оролдож үзэж байсан.

Тэгээд тусгайлсан хөтөлбөр гаргах гэж үзэж байсан.

Тэгэхээр энэ дээр Та бүхэн энэ залгамж чанар юу байна? Юу анхаарахаар байна гэдгийг салбар салбарын холбоод байгаа учраас Та бүхэн хэлээд өгөөч ээ. Тэгвэл бид дараа дараагийн хурал дээр хууль тогтоомжийн шийдвэр гаргахад тодорхой нөлөөлөөд явъя гэсэн ийм бодолтой байна.

Тэгээд холбоодыг бүгдийг нь хариулаасай.

Н.Батсүмбэрэл: Хоёр мэргэжлийн холбоо хариулаад, араас нь яам хариулах уу? Индрийн микрофон нээе.

М.Нарангэрэл: Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны гүйцэтгэх захирал М.Нарангэрэл байна.

Жуулчин тээврийн салбар холбооноос хүн ирсэн байгаа.

Жуулчин тээврийн салбар жуулчин тээвэр дээр 12 жилээс дээш насжилттай буруу рультэй машиныг жуулчин тээвэрт явуулахыг хориглож байгаа. Энэ хууль гараад 4 жил болж байна.

Тэгээд аялал жуулчлалыг 2023-2028 онд хөгжүүлэх, дэмжих жилийн хүрээнд Авто тээврийн үндэсний төв, Зам, тээврийн яамтай бид хамтарч энэ асуудлыг дэвшүүлээд жил болгон бизнес эрхлэгчдэд хүндрэл учруулахгүйн үүднээс сунгаж өгөөч ээ гэдэг хүсэлтийг тавьсан.

Тэгээд одоо энэ жилээс өгсүүлээд хатуу энэ дээр цаашаа явуулахгүй гэсэн учраас бид 1000 гаруй жуулчин тээврийн жолооч нарын дунд судалгаа явуулаад, 700-аас 800 орчим тээврийн хэрэгсэл яг энэ хуулийн заалтын дагуу хөдөлгөөнд оролцох боломжгүй болж байгаа.

Ер нь цаашдаа жуулчин тээвэр нэгэнт хүн тээвэрлэх нөхцөл байдлын улмаас гарч байгаа хууль учраас “ЧӨЛӨӨЛБЕ” аянд тэр жуулчин тээврийн зөвшөөрөл гэдэг дабл стандарт гаргасан асуудлыг бид цуцлуулах нь зөв гэж харж байгаа.

Хоёрдугаарт, манай жуулчны баазын салбар холбооны тэргүүн С.Алтантуяа энд хүрэлцэн ирсэн байна.

Бид жуулчны бааз, зочид буудлууд дээр 48 цагийн бүртгэл гэдэг асуудлыг Гадаадын иргэн, харьяатын тухай хуульд суулгасан учраас энэ 48 цагийн бүртгэлийн асуудлаар баазуудыг торгох, ийм шинэ систем угсарч энд асуудал үүсгэж байгаа учраас бид баазууд дээр судалгаа хийгээд энэ хоёр асуудлыг “ЧӨЛӨӨЛБЕ” аяны хүрээнд оруулж өгөөч ээ гэсэн хүсэлт байгаа.

Манай аялал жуулчлалын компаниудын бүртгэл сайн дурын үндсэн дээр бүртгэгддэг.

Тэгэхээр жуулчны баазууд гишүүнчлэлийн татвар төлөхгүйгээр заавал бүртгүүлэхгүй байж болдог.

Тур операторуудын бүртгэл яагаад явагдаж байгаа вэ гэхээр Гадаадын иргэн, харьяатын газарт виз олгох, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвараас хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхийн тулд тухайн байгууллагыг тур оператор гэдгийг нотлох шаардлага байдаг.

Хоёрдугаарт, даатгалын компаниуд болон олон улсын байгууллагуудад тур оператор компанийг “аялал жуулчлалын компани” гэдгийг нотлох шаардлага байдаг.

Түрүүн М.Энхцэцэг гишүүний асуултад хариулахад манайх 1 сая 200 мянган төгрөгийн гишүүний татвараар ажлын алба 15 хүнээ цалинжуулдаг учраас бид төрөөс хараат бус энэ бүх үйл ажиллагааныхаа зардлыг хийдэг.

Төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх үүднээс авч байгаа тухайн жилд хэрэгжүүлэх гэрээний биелэлтийг Соёл, спорт, аялал жуулчлалын яамны аудит, сүүлд Их Хурлаас томилогдсон Үндэсний аудитын газрын нийцлийн аудитын шалгалтуудаар бүгдэд нь орсон явж байгаа.

Захиргааны хэргийн хоёр шатын шүүх дээр бас мөн манай талд хууль зөрчөөгүй гэдэг тайлбар ирсэн байгаа.

Тэгээд 1 сая 200 мянган төгрөгийн гишүүний татварыг 18 салбар холбоо хувааж авдаг.

Тэгэхээр нэг байгууллага 3-аас 4 салбар холбоонд харьяалагддаг учраас хуучин авагддаг байсан татварын тогтолцоог нэг байгууллага дотроо... /минут дуусав/

Н.Батсүмбэрэл: Гүйцээж хариулъя. 1 минут.

М.Нарангэрэл: ... хоорондоо зөвшилцөөд энэ хуваарилалт явагддаг учраас энэ байхгүй байгаа.

Тэгээд мөн Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хороо Засгийн газар болон манай Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны вебсайтад төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлсэн болон гишүүдийн татварын зарцуулалтын тайланг жил болгоны 4 сарын 10-ны дотор онлайнд байршуулсан байгаа.

Тэгэхээр манай зарцуулалтын тайлан салбар холбоодуудын тайлан олон нийтэд ил нээлттэй байдаг.

Тэгэхээр Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо олон нийтэд нээлттэй ажилладаг. Бүх тайлан тооцоо, төсөв нь ил байдаг ийм холбоо болж төлөвшсөн байна.

Н.Батсүмбэрэл: Манай техникийнхэн анхаарч байгаад юу яая. Одоо асуултад хариулж байгааг 2, 2 минутад багтаагаад танилцуулъя. Тэгэх үү? Тэгэхгүй бол цаг үрэхгүй байна. Тийм.

Индрийн микрофон. 2 минутаар.

Б.Ижилмөрөн: Би нэг жуулчин тээврийн Та бүхэндээ нэг мэдээлэл тодруулга хийх гэсэн юм.

Ер нь Монголын жуулчин тээврийн салбарын авто тээврийн бүрэлдэхүүн бол ер нь 1000 орчим тээврийн хэрэгсэл байдаг юм байна. 1000 орчим тээврийн хэрэгсэл маань Тээврийн тухай хууль дээр 12 жилээс бага насжилттай, зөв хүрдтэй гэж ийм нэгдүгээр хууль нь.

Энэ дээр болохоор 1000 тээврийн хэрэгслийн маань 60 хувь нь шаардлага хангадаггүй. 60 хувь нь.

Дахиад сая энэ 4 дүгээр сард стандарт шинэчлэгдсэн байна. Стандарт шинэчлэгдээд нөгөө жуулчин үйлчилж байгаа машины суудлын тоо 7-гоос дээш байсан юм. 7-гоос дээшийг нь аваад хаясан.

Ингэнгүүт одоо нөгөө саяын зөрчилтэй 60 хувь дээр нэмэгдээд нөгөө жийпнүүд ороод ирж байгаа юм. Бидний сая ярьдгаар. Энэ жийпнүүд маань нөгөө 470, Ланд 200-аас хөгшин гэдэг. Энэ машинууд маань бас ороод ирнэ. Эд нар маань зөрчилтэй. 60 хувь дээрээ нэмэгдээд 15 хувь болоод ороод ирж байгаа юм.

Ингээд жуулчин тээврийн газрын тээвэр үндсэндээ 75 хувь нь зөрчилтэй болчихоод байна.

Хууль маань шууд хэрэгжихэд боломжгүй учраас л энэ дээр их маш хэцүү байдаг. Ноднин бол ерөөсөө холбооны зүгээс зөрчилтэй тээврийн хэрэгслүүдээ тодорхой хэмжээнд Зам, тээврийн яамтай зөвшилцөлд хүрээд нэг ийм шар наалт таних тэмдгээр явсан юм. Тэрийг нь ч яам сүүлдээ хүлээн зөвшөөрсөнгүй.

Ер нь нөхцөл байдал гадаа бол ерөөсөө орон нутгийн зам дээр байгаа тээврийн байцаагч нар. Одоо энэ зөрчилтэй 75 хувийн тээврийн хэрэгслийг –

- зогсоодог,
- торгодог. Ингээд явахаа байдаг.

■ **Сүүлдээ бүр онгоцноос нь хоцроосон.**

Сая бид Зам, тээврийн яамтай уулзалт хийхэд шинэ дарга, цэрэг солигдсон. Одоо та нарыг ерөөсөө бид энэ хуулиа маш чанга барина л гэж байгаа.

Өмнө нь торгоод явуулдаггүй байсан. Одоо энэ 75 хувь маань бүр муур хулгана болоод ч болтугай явж чадахаа бүр больчихлоо.

Тэгэхээр энэ дээр Та бүхэн минь нэг гаргалгаа гаргаж өгөөч.

Миний хувьд болохоор ингэсэн юм аа. Би Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны дэргэдэх Жуулчин тээврийн салбар холбоо.

Би жолооч нарынхаа бодлыг ингэж ойлгоно. Жолооч нартаа би хэлдэг юм.

Ер нь бид энэ тээврийн хэрэгслээ сайжруулна. Сайн үйлчилгээ үзүүлнэ. Сайн тээврийн хэрэгслээр. Хэдүүлээ 3... /минут дуусав/

Н.Батсүмбэрэл: Сая Б.Ижилмөрөн. Нэрээ хэлээд протоколд оруулаарай.

С.Алтантуяа: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны дэргэдэх Жуулчны бааз байршуулах хэрэгслийн салбар холбооны тэргүүн С.Алтантуяа байна.

Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны дэргэд Жуулчны бааз байршуулах салбар холбоо Ерөнхий хийж байгаа ажлын үндсэн чиглэл нь зөвхөн жуулчны бааз гэхгүй –

- ресорт,
- амралтын газар,
- гэр буудал –

-гээд энэ чиглэлүүдээр судалгаа байнга хийж байгаа юм.

Тэгээд энэ 2019 онд 450-иас 526 жуулчны бааз, амралтын газар үйл ажиллагаагаа явуулж ажилчдын тоо нь 10 мянга 350, ор хоног нь 20 мянга гэсэн хүчин чадалтай байсан бол 2020 онд ковидын үед энэ тоо 112 байгууллага, 1120 ажилчдын тоо, ор хоног нь 4928 болж буусан буусан.

Эргээд 2024-2025 онд эргэж өсөөд энэ тоо нь 720, ажилчдын тоо нь 18-аас 20 мянга, ор хоног нь 46 мянга 400-аас 50 мянга болж өссөн юм.

Монгол Улсын жуулчны бааз, түүнтэй адилтгах сууцны нөхцөл байдлын суурь судалгаа гэдгийг хийх хүсэлтийг Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яаманд тавьсан.

Манай холбоон дотор сургалт, судалгааны хороо буюу н.Батболд багштай Боловсрол, хөгжлийн нийгэмлэг хамтарч энэ судалгааг зохион байгуулахаар 200 гаруй судалгаа хийсэн.

Тэгээд өнөөдрийн байдлаар энэ жуулчны бааз байршуулах хэрэгслийн салбар холбооны гишүүдийн хувьд хөдөө орон нутагт байгаа баазуудын судалгааг хийхэд бид урьд нь 450, 700 гээд байсан бол 1000 гараад явсан байна.

Энэ уул болгон, ам болгонд л 5 гэр, 10 гэр барьсан. Энэ бол ерөөсөө далд эдийн засаг хөгжөөд, тэнд нь ямар ч хяналтгүй болсон байна.

Тэгэхээр энэ судалгааг нарийвчлан хийх шаардлагатай.

Хоёрдугаар асуудал бол зээлийн 6 хувийн зээлийн асуудал дээр манай салбар холбооны гишүүд өнөөдрийн байдлаар 60 гаруй гишүүн... /минут дуусав/

Н.Батсүмбэрэл: Ингэе тэгэх үү. Хэдүүлээ түрүүн тохирсон. Микрофонгүй явахаар протоколд орохгүй.

Тэгэхээр сууж байгаад дахиад ярья. Дараагийн хүн нь явъя. Тэгээд эргээд яая тэгэх үү. Бас зориод ирсэн учраас Та хэдийн үгийг сонсьё гэж байгаа юм. 2 минутад багтаагаад түрүүн танилцуулагдсан ажлын хэсгийн гишүүдээс нэмж ярих саналтай байвал өөрийгөө танилцуулаад яриарай л гэсэн гэсэн санаа.

Микрофон нээе.

Г.Алтаншагай: Сайн байна уу? Монголын аялал жуулчлалын холбоо Г.Алтаншагай байна.

Хоёр асуудлыг маш товчхон хэлье.

▷ **Нэгдүгээрт,** Монгол Улсад нийтдээ 300-аас 400 орчим жуулчны бааз байна гээд байгаа юм.

Тэгээд ихэнх нь газар нутгийн хувьд **“тусгай хамгаалалттай газар”** байршдаг. Яагаад гэвэл манай хамгийн гоё үзэсгэлэнтэй байгаль оршдог учраас тэр нь тусгай хамгаалалттай байдаг. Тэгэнгүүт тусгай хамгаалалттай газар жуулчны бааз эрхлэхээр нөгөө **“тусгай хамгаалалттай газрын тусгай зөвшөөрөл”** гэж өгч байгаа юм. Тэр нь 5-хан жилээр байдаг. 5 жил тутамд үүнийг сунгадаг гэсэн үг.

• Тэгэхээр энэ аягүй төвөгтэй байдлыг бий болгож байгаа юм.

Яагаад гэхээр зэрэг жуулчны бааз гэхээр зөвхөн гэр биш, тэнд чинь ресторан, тийм ээ усанд орох газар, байгууламжуудыг барьдаг. Хүмүүс маш их хэмжээний хөрөнгө оруулалтыг хийдэг.

Гэтэл эргээд тэр оруулсан хөрөнгө оруулалтаа жишээлбэл банканд ч юм уу тавиад зээл авъя гэхээр банк барьцаанд авч зээл авдаггүй. Бид өөрсдөө хөрөнгө босгоё гэхээр болдоггүй.

Тэгэхээр үүнийг доор хаяж 30 жил. Тийм ээ. 40-өөс 50 жил болгож байж эргээд бидний оруулсан хөрөнгө оруулалт маань үнэ цэнтэй болно. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, дахин дахин төрийн байгууллагад бичиг баримт бүрдүүлээд 5, 5 жилээр сунгагдаад яваад байх асуудалгүй болж байгаа юм. Яг энэ “ЗӨВШӨӨРЛИЙГ ЦУЦАЛЪЯ” гэж байгаа аяны хүрээнд үүнийг эн тэргүүнд өөрчлөх хэрэгтэй. Хугацааг нь их болгох хэрэгтэй байгаа юм.

Дараагийн асуудал нь байгаль орчны үнэлгээ гэж явдаг. Энэ нь бас л тодорхой жил тутамд байгаль орчны үнэлгээгээ хийдэг.

Жуулчны баазууд уурхай ч юм уу, эсвэл бусад газраас ялгаатай. Харин байгаль орчиндоо илүү ээлтэй, байгаль орчноо хамгаалдаг.

Би жишээлбэл, хувь бизнес эрхлэгчийн хувиас хэлэхэд манайх ойр орчноо мод тариад. Тийм ээ. Ерөнхийлөгчийн тэрбум мод аян гэхэд л мод тариад ойр орчноо хамгаалаад хоггүй байлгаад явж байдаг мөртлөө байгаль орчны үнэлгээ гэдэг юмыг бас хийлгэдэг.

Энэ нь бас 3, 5 жил тутамд 5 сая төгрөгөөр хийлгэж байгаа. Одоо бас үнэ нь өсөөд 7, 8 сая төгрөг ч юм уу болж байгаа.

Тэгэхээр энэ зүйлийг хугацааг нь уртасгах, үүнийг өөрчлөх цуцлах хэрэгтэй байгаа юм. Миний санал бол ийм байна.

Н.Батсүмбэрэл: Хэдүүлээ ингэе. Одоо бол Б.Тулга гишүүний асуултад хариулж байгаа шүү дээ.

Асуулт дууссаны дараа энд ирсэн ажлын хэсгийн гишүүд буюу Та бүхэн 2, 2 минутад багтаагаад байр сууриа хэлчих. Та бүхний энд хэлсэн үгүүд ажлын албан дээр тэмдэглэл болоод, энэ асуудлын мөрөөр ажил хийгдэнэ гэсэн үг шүү дээ.

Индрийн микрофон нээе.

Б.Түвшинжаргал: Сайн байцаана уу? IBIS Styles Улаанбаатар зочид буудлын гүйцэтгэх захирал Б.Түвшинжаргал байна.

Тэгээд гишүүний тавьсан асуултын хүрээнд зочид буудлын үйл ажиллагаа явуулж байгаа зочид буудал гэдэг бизнесийн асуудлын тухай л ярья. Ер нь. Өөрөө холбооны юу бол биш.

Манайд хамгийн түрүүнд яригддаг асуудал гэвэл төрийн олон агентлаг, төрийн байгууллагуудын ордог шалгалт шүүлэг. Яах вэ, үүнийг Н.Учрал сайд “ЧӨЛӨӨЛЪЕ” гээд ярьж байгаа.

Гэхдээ яг өмнө долоо хоногт манайд 4 хоног дараалаад шалгалт орж ирж байгаа байхгүй юу.

Тэгээд ингээд хэдэн газраас, хаанахаас ирж байна вэ гэсэн чинь одоо ингээд л зүгээр хэлэхэд –

- Соёлын яамнаас ирж байгаа,
- Цагдаагийн ерөнхий газраас ирж байгаа,
- АТГ-аас ирж байгаа,
- Онцгойгоос ирж байгаа,
- Мал эмнэлгийн ерөнхий газраас ирж байгаа,
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам,
- Байгаль орчин яам,
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам.

Бүхэл бүтэн хоног хоногжингоо шалгалт болж байгаа байхгүй юу. Тийм ээ.

Тэгэхээр үүнийг төр үнэхээр шийдэж болно шүү дээ. Тийм ээ.

Үүнийг ганц стандартаа бариад, ганц зочид буудал, ресторан.

Байгаль, одоо юу гэдэг юм мал эмнэлэг яагаад орж ирж байгаа юм. Сүүлдээ өөрсдөө ч ойлгохгүй тийм нөхцөл байдал үүсэж байгаа юм.

Дараагийн зочид буудал дээр яригдах хамгийн том юм бол яах вэ, 2023 онд шинэчилсэн аялал жуулчлалын шинэ хууль гээд ярьж байгаа. Энэ дээр зочид буудал буюу энэ чинь туристүүдийн хамгийн том байрлах байр шүү дээ. Тийм ээ. Түр байр.

Гэхдээ манай зочид буудал жуулчин бааз ч юм уу татварын ямар нэгэн хөнгөлөлт байхгүй. Бид энэ салбарын уг нь төвд нь яваад байгаа бизнесийн нэг unit байхгүй юу. Тийм ээ.

эхдээ ямар нэгэн татварын юу байхгүй. Манайх л гэхэд 13 төрлийн өөр татвар төлдөг. Өвлийн үед гэхэд нэлээн том байшин мөртлөө нэг л өрөөтэй хонож байхад татвараа төлөөд л явна.

Н.Батсүмбэрэл: Өөр хүн байгаа билүү? Асуултад хариулах. Та индэр дээр. Тэгээд В.Батчимэг дарга дараа нь хариулах билүү? Индэрийн микрофон.

С.Баясгалан: Б.Тулга гишүүний асуултад хариулъя.

Тэгээд өвлийн аялал жуулчлал дээр хэрхэн ямар бодлоготой байгаа вэ гэж байна.

Ер нь бид улирлын хамаарлыг бууруулах л бидний аялал жуулчлалын хамгийн гол зорилго байгаа.

Энэ дээр түрүүн хэлсэнчлэн “хотын татвар” гэдэг 2014 онд ер нь аялал жуулчлалыг дэмжих чиглэлд бий болгосон. Жуулчны бааз, Улаанбаатар хотын Тэрэлжээс хүртэл авч байгаа 2 хувийн татвар.

Үүний тодорхой хувийг аялал жуулчлалын салбарын яг өвөл жуулчин авчирч байгаа компанийн жуулчин тус бүр дээр дотаци өгөх, эсвэл өвлийн нислэг дээр дотаци өгөх замаар нислэгийн үнийг бууруулах, эсвэл өвөл дотооддоо аялах иргэдийг.

Ер нь Монгол Улсын аялал жуулчлалын салбарын худалдааны тэнцэл чинь гадагшаа аялж байгаа жуулчид өвөл 1 дүгээр сард зөвхөн 1 тэрбум долларыг зарцуулж байгаа.

Тэгэхээр дотооддоо аялж байгаа төрийн байгууллагуудын ч юм уу. Тийм ээ. Иргэдэд ямар нэгэн хөнгөлөлтийн үнэ үзүүлэх замаар дотоодын аяллаа дэмжихэд чиглүүлэх юм бол бид өвлийн аяллыг эхний ээлжид шийдэж болох байх гэж байгаа.

Тэгээд дараагийн бидний “ЧӨЛӨӨЛЬЕ” аяны хүрээнд нэг шийдвэрлэх асуудал нь хүний нөөцийн асуудал байгаа. Яг 3 сарын хугацаанд бид гаднын ажиллах хүчин авч, ер нь хүний нөөцийн салбараа шийдэх ёстой. Яагаад гэхээр орон нутагт ажиллаж байгаа ч юм уу, аялал жуулчлалын баазууд дээр орон нутгийн иргэдийг аваад ажиллуулахаар найр наадам гээд яг зун ажлын байр хаяад явдаг. Тэгээд жуулчдын сэтгэл ханамжийн асуудал гарч ирдэг.

Тэгэхээр 3 сарын хугацаанд түр ирж байгаа гадаадын ажилчдыг аялал жуулчлалын салбарт тодорхой бодлого гаргаад тэр улсад төлдөг төлбөрөөс тодорхой хэмжээнд чөлөөлж өгч болох уу. Дараагийн хөдөлмөрийн хүний нөөцийнхөө асуудлыг шийдтэл.

Тэгээд хамгийн гол нэг асуудал бол тэр “хил орчмын аялал жуулчлал”. Үүнийг яаралтай шийдэж өгөөч ээ гэж байгаа.

Тэгэхээр энэ хил орчмын аялал жуулчлалын асуудлыг шийдсэнээр бид 11 орчим аймагт эдийн засгийн томоохон хэмжээний урсгалыг бий болгох боломжтой байгаа. Баярлалаа.

Н.Батсүмбэрэл: Яам нэгтгээд хариулаагүй юм байвал хариулах нь ээ. Индрийн микрофоныг нээе.

В.Батчимэг: Б.Тулга гишүүний асуултад хариулъя.

Зээлийн асуудлыг удаашралтай байсан уу гэсэн асуулт байсан. 2026 оны Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын багцад 13 тэрбум төгрөг зээлийн дотаци нь батлагдсан байсан.

Үүний дагуу бид талуудтай гэрээ байгуулах байсан. Сангийн яам, Монголбанк, арилжааны 10 банкттай хамтарч гэрээ байгуулах байсан. Энэ дээр өмнөх 2024, 2025 оны хүүгийн дотаци олгогдоогүйн улмаас бусад банкуудад асуудлыг тавих. Дээр нь нөгөө шаардлага, шалгуур үзүүлэлтүүд дээр асуудал үүссээр байгаад нэг, хоёр сарыг бид алдсан юм.

Тэгээд 2026 онд бид төсөв батлуулж байхад 180 тэрбум төгрөгийн хэмжээнд зээл олголт байсан бол нэг, хоёр сар өгөөгүйн улмаас 250 тэрбум төгрөг болж өссөн тооцоолол гарсан.

Тэгээд түрүүний миний танилцуулгууд байгаа. Би танд тусгайчлан танд өгье гэж бодож байна.

Бид зээлд хамрагдаж байгаа бүх аж ахуйн нэгжүүдийгээ нээлттэй шилэн байлгана гэдэг дээр яам бодлогын яамны хүрээнд анхаарч ажиллана.

Бид өвлийн аялал жуулчлал дээр 2023 оноос хойш бид ч үгүй жил болгон өвлийн аялал жуулчлалын төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанаар оруулж батлуулдаг болсон. Энэ хүрээнд 2024 онд бид өвлийн баазуудад шөнийн тарифын хөнгөлөлт үзүүлж байсан. С.Алтантуяа эгч. Тийм биз дээ. Тийм ээ.

Тэгэхээр үүн шиг бид цаашид дэмжих бодлогуудыг баримтална.

Бид энэ 2026 он гарснаар –

- ➔ 1 сарынх 44 хувийн өсөлттэй.
- ➔ 2 сарынх 38 өсөлттэй.
- ➔ 3 сарынх 39 хувийн өсөлттэй байгаа.

Бас бид энэ хийж хэрэгжүүлж байгаа ажлын үр дүн болов уу гэж бодож байна.

2026 он. Сая Та бүхэн харсан байх. Говийн бүсүүд харьцангуй цаг агаарын хувьд дулаан учраас бид говийн бараг бүх аймгууд дээр тэмээний баяруудыг хийсэн. Энэ мэтчилэн бид өвлийн спорт, тэр бусад боломж... /минут дуусав/

Н.Батсүмбэрэл: Яам гүйцээд хариулъя. 1 минут сунгая.

В.Батчимэг: Тулгуурлаад бид өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлж байгаа юм.

Ер нь хил орчмын аялал жуулчлалыг маш яаралтай хийж хэрэгжүүлэхээр болсон. Өмнөх долоо хоногт манай дэд хорооноос бидний дуу хоолойг сонссоны хүрээнд энэ ажил маань ажил хэрэг болоод өчигдөр бид эхний уулзалтаа хийсэн. Нааштай шийдэгдэж байгаа.

Бид эхний удаа Дорнодын Сүмбэрийн боомт буюу Замын-Үүд хоёрыг нээж үзье гэдэг тохиролцоон дээр өчигдөр анхаарлаа хандуулсан.

Маршрутыг батлахаар болсон. Одоо батлаагүй байна. Ер нь батлахаар болсон.

Гадаад хэргийн яам өчигдөр уулзалт дээр ирсэнгүй. Гадаад хэргийн яамны төлөөллүүдтэй уулзалтаа хийгээд, Гадаадын иргэн, харьяатын газар манай хоёр дахиж яриад, тэгээд Хууль зүйн яаман дээр эргэж уулзахаар болсон.

Хил орчмын аялал жуулчлалыг бид нээхэд боомтуудын хүчин чадал харьцангуй асуудалтай байгаа учраас цаашдаа бид боомт дээрээ түшиглээд боомтоо өргөжүүлэх, сайжруулах, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх. Мөн цаашлаад өвлийн үеүдэд боомт... /минут дуусав/

Н.Батсүмбэрэл: Б.Тулга гишүүн тодруулах уу? Б.Тулга гишүүний микрофон.

Б.Тулга: С.Баясгалан дарга байж байх шиг байна. С.Баясгалан дарга чинь хуучин ялангуяа хууль баталж байх үед та чинь Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд байсан. Тийм ээ.

Тэгэхээр түрүүний юун дээр гарч байгаа тэр Байгаль орчны яамнаас өгч байгаа газар ашиглуулах зөвшөөрлүүд. Тийм ээ. Эзэмших биш. Тийм ээ. Тэр чинь ашиглах шүү дээ.

Тэр ашиглах зөвшөөрлүүд урт хугацаатай гэдэг юм уу, тийм болоход болохгүй юм бий юу? Ер нь. Индэр хариулчих. Тийм ээ.

Н.Батсүмбэрэл: Индэрийн микрофон нээе.

С.Баясгалан: С.Баясгалан Монголын аялал жуулчлалын холбооны Ерөнхийлөгч.

Яг одоогийн байдлаар Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга явж байгаа.

Тэгэхээр энэ шинэчилсэн найруулга дээр хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангахад энэ зохицуулалт орох боломжтой.

Яагаад гэвэл улсын тусгай хамгаалалттай бүс нутагт энэ зохицуулалтууд яваад байгаа. Тийм. Байж байгаа.

Н.Батсүмбэрэл: Баярлалаа. Ианыг индэрт урьж байна. Индрийн микрофон нээе.

Э.Наранхүү: Сайн байцгаана уу? Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны дэргэдэх Солонгос зах зээлийн салбар холбооны тэргүүн Э.Наранхүү гэж хүн байна.

Би Солонгос зах зээлийн аялал жуулчлалаа төлөөлдөг болохоор хэдхэн зүйл богинохон хэлэх гэсэн юм.

Түрүүн яагаад tour operator-ууд болон tour guide-ууд яагаад гэрчилгээтэй байх ёстой вэ гэдэг тал дээр яригдаж байна.

Би ингэж үздэг юм. Зах зээлийн холбоодоо төлөөлөөд ярих юм бол. Бид заавал ийм тусгай зөвшөөрөл, гэрчилгээтэй байх ёстой. Яагаад гэхээр бид жуулчин хүний амь насыг аваад тээгээд явж байдаг байхгүй юу.

Тэгэхээр өнгөрсөн жил Та бүхэн сонссон байж магадгүй. Хоргын тогоонд 8 сард нэг жуулчин хаднаас унаад амь насаа алдсан тохиолдол гарсан.

Тэгээд тэр компани маань Солонгосоос нэг тур оператор Монгол руу зүгээр нэг хувь guide руу явуулсан ийм аялал гарсан.

Тэгээд одоо болтол энэ тал дээр энэ хүний амь насны хохирлын талаар яригдаж байгаа болохоор явж явж хэн буруутай вэ, хэн энэ үйл ажиллагааг хийж байгаад ямар ёс журмын дагуу явж байгаад энэ хүний амь нас эрсдэв ээ гээд яригддаг болохоор бид энэ tour operator-ууд болон tour guide-уудыг заавал бүртгэлжүүлж, тусгай сургалтжуулж, гэнэтийн осол, аваарын үед яаж энэ хүний амь насыг хамгаалах ёстой вэ гэдэг дээр заавал сургалт орох ёстой.

Тийм болохоор энэ бүх зүйл ингээд бүртгэлээр явдаг. Та бүхэн сайн мэднэ. Бид алт ухахдаа тусгай зөвшөөрөл авч байгаа. Архи зарахдаа тусгай зөвшөөрөл авдагтай адилхан жуулчин маань өөрөө нөгөө хүний амь насыг хариуцаад явдаг ийм үйлчилгээний том салбар болохоор ийм зөвшөөрөл, ямар нэгэн бүртгэл заавал авах ёстой байдаг.

Тэгээд tour operator-уудад тулгамдаж байгаа хэд хэдэн асуудал байгаа.

Тэгээд бүгдээрээ ингээд нөгөө хоорондоо аалзны тор шиг холбогддог болохоор түрүүн манай П.Мөнхжаргал захирал хэлж байна, Б.Ижилмөрөн маань хэлж байна. Хоорондын яг ийм зовлонгууд байна.

Бидэнд яг тулгамдаад байгаа асуудлууд гэх юм бол виз олголтын асуудал, хил дээрээс буцаагаад байгаа асуудлууд дээр Та бүхэн нэг харж анхаарч өгөөч ээ. Жуулчид маань том асуудалгүй байтал хохирч буцаад байна.

Дээрээс нь жуулчны даатгал. Өөрийн орноос ирэхдээ амь насны даатгал хийлгээд ирж байгаа болохоор... /минут дуусав/

Н.Батсүмбэрэл: 1 минут сунгая.

Э.Наранхүү: Баярлалаа. Та бүхэндээ.

Монголд ирээд даатгалаа заавал хийлгэх ёстой юм уу, эсвэл сонголтоороо хийлгүүлэх ёстой юм уу. Энэ дээр харж өгөөч.

Өвлийн аялал жуулчлал дээр бид аягүй их хичээж байна.

Тэгээд баазууддаа тог цахилгааны хөнгөлөлт өгөөд явж байсан. Энэ тал дээр их баярлаж байгаа. Энэ жил Хөвсгөлийн хойшоо Ринчинлхүмбэ, Жаргалант руу солонгос жуулчид их сайн явсан. Ирэх жил ч гэсэн бид их сайн явуулахыг их зорьж байна.

Тэгээд орон нутгийн шууд нислэгийг аягүй их хүсэж байсан. Түрүүн П.Мөнхжаргал захирлын хэлснийг сонсоод салбар болгон доор бүрнээ маш их асуудал байдаг болохоор бас энэ удаа ингээд орхиё.

Тэгээд нэг зүйл гуйх гэсэн юм. Бидэнд өнөөдөр Монгол Улсад яг энэ аялал жуулчлал Солонгос салбар дээр өөрсдийн гэсэн контент алга. Одоо Монгол Улсыг “Welcom to Mongolia” ч гэдэг юм уу, ийм сурталчилсан контент байхгүй болохоор бид ийм контент хиймээр байна.

Тэгээд тур операторууд энэ хөнгөлөлттэй зээлд орж чадахгүй байгаа болохоор компаниуд бухимдаж байгаа.

Тэгээд үүгээрээ контент хийгээд, эргээд өөрсдийн гэсэн нөгөө суваг, платформ, маркетинг хийгээд жуулчдыг татах... /минут дуусав/

Н.Батсүмбэрэл: Би нэг асуулт, санал байна.

Өмнөх хурал дээр манай яам нэлээн сайн мэдээлэл өгсөн.

Тэгээд тэр мөрөөр дэд хорооноос 3 яаманд, 3 сайдад хил орчмын аялал жуулчлалыг яаралтай эхлүүлэх талаар бичиг явуулсан. Ажил явагдаж байгаа юм байна. Энэ ажил дээр цаашид ямар дэмжлэг хэрэгтэй байна аа? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, сая хэд хэдэн удаа хөндөгдөөд байгаа нөгөө хүнд суртлыг бууруулъя, чөдөр тушааг чөлөөлье гэж яриад яваад байгаа ажилд энэ салбар

дээр ямар ямар хүндрэлүүд байна. Түүнийг яаж бид шийдэх бололцоо байна. Энэ дээр Та бүхэн саналаа өгөөч.

Тэгээд ер нь Аялал жуулчлалын хөгжлийн дэд хороо бол Эдийн засгийн Байнгын хорооноос байгуулагдсан дэд хороо.

Тийм учраас бид хэд хэдэн уулзалтынхаа дараа Эдийн засгийн байнгын хороонд саналаа оруулаад, магадгүй хэрэгтэй гэж үзвэл Их Хурлын тогтоол гаргаж болох юм. Аялал жуулчлалыг хөгжүүлэх асуудлаар Засгийн газарт чиглэл өгсөн.

Тэр дотор саяын яриад байгаа энэ хүнд суртлуудыг багасгая, олон шат дараалсан тэр зочид буудал дээр гарсантай адилхан шалгалтуудыг стандартад нийцүүлж яаж өөр болгох вэ.

Мөн мэргэжлийн холбоодыг хооронд нь уялдаж ажиллахад нь хууль эрх зүйн хувьд ямар боломжуудыг өөрчилж болох вэ.

Тэгээд саяын яриад байгаа тэр цахим төлбөрөөс эхлээд гадаад сурталчилгаануудыг сайжруулах дээр Засгийн газартаа яаж дэмжлэг үзүүлэх вэ.

Аялал жуулчлалыг дэмжих чиглэлийн тэр зээлүүдийг эх үүсвэрийг нь нэмэгдүүлэх, болзлыг нь илүү сайжруулах тал дээр бид яаж дэмжлэг үзүүлж болох вэ гэдэг тал дээр Их Хурлын тогтоол санаачлах хэмжээнд ажиллаж болж байна.

Тэгэхээр Та бүхэн гол нь мэргэжлийн яам маань, мэргэжлийн холбоод маань саналаа сайн өгөөрэй гэж Та бүхнээс хүсье.

Т.Билэг-Өрнөх гээд тэр залуу. Билигээ бос доо. Энэ залуу манай дэд хорооны ажлын албаны залуу байгаа. Энэ залууд Та бүгд саналаа өгөөд явбал бид ингээд шуурхай, цаг хүлээхгүйгээр Та бүхний ажлуудыг хялбарчлах дээр анхаарч ажиллана гэдгээ хэлье.

Тэгээд энэ дээр ямар байдлаар нэгтгэж саяын ажлуудыг хийж болох вэ гэдэг дээр яам маань нэгтгээд нэг хариулах уу?

В.Батчимэг даргыг индэрт урья. Нэгтгээд та саяын асуултад санаа бодлоо хэлээч. Индрийн микрофон.

В.Батчимэг: Дэд хорооныхоо даргад баярлалаа.

Бид бүгдийн асуудлыг яаралтай авч хил орчмын аялал жуулчлалын олон жил яригдаж байгаа, ялангуяа энэ Ойрхи Дорнодын асуудлын дайн байлдааны тогтворгүй асуудалд хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлснээр бид дараагийн шатны тогтвортой өсөлтөө хамгаалахад манай салбарт анхаарахад яалт ч үгүй –

- Хил орчмын аялал жуулчлал,
- Хил дамнасан аялал жуулчлал,
- Цайны замын аялал жуулчлал,
- Торгоны замын аялал жуулчлал –

-гэсэн брэнд аяллуудыг бид хийж хэрэгжүүлэхэд том гарц гаргалгаа болох юм.

Тэгээд миний бие энэ хил орчим дээр Хууль зүйн яамтайгаа ойлголцсон. Дээр нь иргэний харьяаттайгаа ойлголцсон. Одоо бид Гадаад харилцааны яамтай тэр цагаан хуудсаар зорчих уу, яах вэ гэдэг асуудлыг ярих юм бол бас нэг тодорхой хэмжээний шийдэлд хүрэх байх гэж би бодож байна.

Манай холбоодод манай энэ Монгол Улсынхаа эдийн засагт манай салбар маань сүүлийн жилүүдэд эрчимтэй үр өгөөжөө өгч байгаа учраас манай салбарынхан нэгдэж хамтарч урагшилж чадна гэж миний бие бодлогын газрын даргаар ажиллаж байгаа хүний хувьд хэлж чадна. Болохгүй юм бол байхгүй. Өнөөдрийг хүртэл хүчээ нэгтгэж явсан.

Зээлийн санхүүжилт дээр миний хувьд ийм санал байгаа. Тэгэхдээ Та бүхэн маань цаашид анхаарч өгвөл их зүгээр байна.

Бид **Inbound, Outbound**-аас гарч байгаа, орж байгаа жуулчдаас бид нисэх дээрээс ул мөрөө үлдээж байгаа юм уу, хог хаягдлынх ч гэдэг юм уу татвар авахад нэмэлт орлого бүрдүүлэх боломж байгаа гэдгийг би харж байгаа. Олон улсын жишиг дээр байдаг. Япон гэхэд хил дээрээ 7 долларын төлбөр авдаг жишээтэй. Тийм ээ.

Тэгэхээр цаашид манай аялал жуулчлалын салбар маань заавал ч үгүй төрийн төсвөөс гэхээсээ илүү нэмэлт орлогуудыг оруулаад эргүүлэн зарцуулах.

Түрүүн С.Баясгалан дарга хэлж байна. Хотын 1 хувь чинь одоо бүр 2 болсон. Одоогоор бүр 40 тэрбум төгрөг нийслэлд орлого оруулж байгаа.

Тэгэхээр энэ мэтчилэн эргээд энэ орлогоосоо, аялал жуулчлалын салбар, энэ хөрөнгө оруулалтын салбарт зарцуулдаг байх, эгүүлэн зарцуулах гэдэг асуудал.

Манай 2023 оны тухай хууль дээр Аялал жуулчлалыг дэмжих сангийн асуудал явж байсан. Их Хурал дээр очоод унасан. Би тэр үед Нийслэлийн Аялал жуулчлалын газар байхдаа Нийслэлийн эрх зүй зүйн байдлын тухай хууль дээр нийслэл нь Аялал жуулчлалын сантай байж болно гээд оруулсан байгаа.

Тэгээд Их Хурал дээр манай салбарын том улсын хэмжээний сан маань унасан байгаа.

Тэгэхээр ер нь манай салбар бизнес эрхлэгчдийн нуруун дээр явдаг салбар учраас сантай байхад болохгүй асуудал манай салбарт байхгүй. Түүн дээр Та бүхэн маань хуулийн гарц, гаргалгааг гаргаж өгөх нь зөв байх.

Ер нь цаашлаад бид аймаг, орон нутгууд дээр ч гэсэн яагаад зочид буудлын 1 хувийн татварыг авч болохгүй гэж. Тэнд хог хаягдал байж байна, ул мөрөө үлдээж байна, олон улсын стандарт бүхий иймэрхүү татваруудын бодлогууд байдаг. Баярлалаа.

Н.Батсүмбэрэл: Гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Одоо санал хэлнэ. Санал хэлэхийн урьдаар ажлын хэсэг буюу энд урьж ирүүлсэн хүмүүсийнхээ саналыг сонсчих уу. Эхлээд. Гишүүд ээ.

Тэгэхээр индрийн микрофон 2, 2 минутаар нээгдэнэ.

Ингээд орхигдуулсан асуудал, нэмж хэлэх ёстой гэж бодож байгаа асуудлыг бол Та бүхэн хэлээч ээ. Аялал жуулчлалын асуудал бол бидний чухал асуудал.

Тийм учраас бид энэ дээр цаг зараад, Та бүхэн ирсэн. Ингээд сонсьё гэж үзэж байгаа юм.

Тэгээд цаанаасаа эхлээд явчих уу болно. Өөрсдөө шаардлагагүй гэж бодож байгаа бол болно. Тэгээд индэр дээр очоод 2 минутад багтаагаад. Дэлгэц дээр цаг гарч байгаа.

Т.Баттулга: Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны ерөнхийлөгч Т.Баттулга. Би товчхон хэлье.

Аялал жуулчлалын салбарын Монголд ер нь хамгийн том асуудал. Манай аялал үнэтэй. Бусад улстай харьцуулбал үнэтэй болж байгаа. Энэ нь түрүүн П.Мөнхжаргал дарга маш тодорхой шалтгаануудыг нь хэлж байна лээ.

Тэгээд энэ үнэ, өртгийг нь багасгах тал дээр л манай төрийн бодлого анхаарч өгөөч ээ л гэж бид хүсдэг.

Тэгээд ер нь тэр Airline-ийн дотаци гэдэг юм уу, өвлийн аялал жуулчлалын хөнгөлөлт, цахилгааны хөнгөлөлт гэдэг юм уу, энэ бодлогууд зайлшгүй байх шаардлагатай юм байна.

Хоёрдугаарт нь, бас үнэтэй болгож байгаа зүйл нь тэр элдэв дарамт, чирэгдэл, төрийн шалгалт, хяналт энэ бүхэн өртгийг нэмэгдүүлж байгаа. Цаг хугацаа маш их үрж байгаа. Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулдаг жуулчны баазуудын 80 орчим хувь нь тусгай хамгаалалттай газар байдаг. Тэр нь 5, 5

жилээр ашиглалтаа сунгадаг. Тэр болгонд маш их бичиг баримт бүрдүүлэх, тэр нь бараг нэг хүн ажиллуулдаг байдалтай байгаа. Жуулчны бааз нэг хүнийг зөвхөн тэнд ажиллуулахын төлөө тэрийг даахгүй байгаа.

Ерөнхий сайдын гаргаж байгаа “**ЧӨЛӨӨЛЬЕ**” гэсэн аяны хүрээнд бид бүр жагсаалт гаргаж өгье гэж бодож байгаа.

Жуулчны баазууд, зочид буудлууд, тээвэр дээр яг ийм ийм зүйлийг “**ЧӨЛӨӨЛЬЕ**” аяны хүрээнд чөлөөлж чөлөөлж өгөөч ээ гэж. Бүрмөсөн алга болгож өгөөч ээ. Өөрөөр хэлбэл бид элдэв дотаци, төрийн үнэгүй мөнгө хүсэхээс илүү зүгээр элдэв дарамтыг л чөлөөлж өгөөч гэж хүсэж байгаа юм.

Гурав дахь асуудал. Түрүүн НӨАТ-ын асуудал ярьж байсан.

Ер нь энэ тур оператор НӨАТ төлдөггүй юм. Тэгэхдээ эргээд жуулчны баазууд болон бусад бүх үйлчилгээнүүд очоод НӨАТ-тай болдог. Ялгаа байхгүй НӨАТ-ын зардал тэндээс гараад л ирдэг.

Тэгэхээр энэ аялал жуулчлалын салбар өөрөө эмзэг, дээр нь ийм үнэтэй салбар байгаа учраас ер нь энэ НӨАТ-ын асуудлыг аялал жуулчлалын салбарт үйлчилж байгаа бүх секторт нь тэгшид нь яаж өгч болохгүй юм уу гэж. Одоо тэглэж өгөх ямар боломж байна гэсэн ийм л яг энэ аялал жуулчлалын салбарын өртгийг нь бууруулж байж Монголын аялал жуулчлал дэлхийн, энэ Зүүн Азийнхаа зах зээл дээр өрсөлдөх чадвартай болох юм л гэдгийг хэлмээр байна.

Тэгээд тэр **outbound**-ыг ер нь дэмжих шаардлагагүй гэж боддог. Миний хувьд. Тэгж байж Монголын эдийн засаг өөрөө өрсөлдөх чадвараа хамгаалаад явна.

Тэгээд энэ **inbound**-ыг илүү дэмждэг. Тэр **outbound** руу илүү мөнгө гадагшаа... /минут дуусав/

Н.Батсүмбэрэл: Өөр хүн байвал индэр дээр очоод. Индрийн микрофон нээе.

П.Мөнхжаргал: “Хүннү Эйр” компани П.Мөнхжаргал. Баярлалаа. 2 минутад багтаах гээд л үзье дээ.

▷ **Нэгдүгээрт**, орон нутгийн нислэг НӨАТ-тай. Бусад бүх тээвэр НӨАТ-гүй.

- Орон нутгийн автобус,
- нийтийн тээврийн автобус,
- такси, галт тэрэг бүгд НӨАТ-аас чөлөөлөгдсөн.

Ганцхан бид заналтай юм шиг орон нутгийн нислэгийг НӨАТ-тай.

Чөлөөлөөд өгөөч гээд сүүлийн 5 жил гуйлаа. Өгөхгүй байгаа. Үндсэндээ 2 тэрбум төгрөгийн л асуудал байдаг. Гэтэл тэр 2 тэрбум төгрөгийг чинь аялал жуулчлалынхан, жуулчид төлөөд байгаа байхгүй юу. Энэ нэг тийм байгаа.

▷ **Хоёрдугаарт**, өвлийн аялал жуулчлал дээр бид сүүлийн үед ер нь гадагшаагаа бараг 2 сарын хугацаанд тэрбум төгрөг гараад байгаа.

Гэтэл сүүлийн үед улсууд юу болсон бэ гэвэл зөвхөн дотоодын авиа компаниар нис гэдэг шаардлага тавьсан. Жишээлбэл, Оросын Холбооны Улс сая тийм шаардлага тавиад Оросоос Хятад руу явж байгаа Оросын Холбооны Улсын жуулчид явж байгаа бол зөвхөн Оросын Холбооны Улсын агаарын тээврийн компаниар явна гэсэн. Мөнгөө улсдаа авч үлддэг.

Одоо манайх юу болж байна гэхээр өвөл болонгуут Вьетнам, Хятадын **low-cost carrier**-ууд орж ирээд манай мөнгийн ихэнх хувийг аваад явдаг. Үндсэндээ бид жуулчдынхаа урсгалыг барьж чадахгүй.

Гэхдээ ямар ч байсан мөнгийг нь нутагтаа үлдээмээр байгаа юм. Энэ дээр ер нь нэг тийм төрийн бодлого гарахгүй бол бид мөнгөө алдаад л байна.

Бид Манжуур хотыг жилдээ 5 мянган хүн явдаг жижигхэн хот байхад нь –

- онгоцоор 50 мянган хүн,
- газраар 150 мянган хүн явуулдаг болгож өгсөн.

Бид Манжуур хотыг хөгжүүлэхэд аягүй үнэтэй хувь нэмэр оруулсан.

Гэхдээ тэрний цаад шалтгаан нь юу байна. Манжуур хотын захиргаа нислэг болгонд зорчигчийн тоогоор дотаци өгдөг байсан. Дотацийг нь авахаараа яадаг вэ гэхээр хямд үнэ санал болгодог. Улаанбаатар Манжуурын нислэг үндсэндээ 50 доллар гаруйхантай л, 50 гаруй доллар л болгосон.

Тэгээд зөрүүг нь Манжуур хотын захиргаа өгөхөөр манай Монголчууд чинь хямд үнэ харахаар бүгд явдаг. Явсан хойноо мөнгөө замбараагүй үрдэг. Жилдээ бидний тооцоолсноор 2-оос 3 сая доллар хуучин зарцуулдаг байсан. Энэ бол тэр улсуудын арга, бизнесийн ухаан.

Үүнийг бид... /минут дуусав/

Н.Батсүмбэрэл: Дараагийн хүн байна уу? Индрийн микрофон нээе.

С.Баясгалан: Ерөнхийдөө хоёр бодлогын шийдэл танилцуулъя гэж бодож байна.

Нэгдүгээрт, санхүүгийн хэрэгцээ шаардлага, санхүүгийн бүтээгдэхүүн маш өндөр байгаа нь харагдаж байгаа. Яагаад ер нь аялал жуулчлалын салбарт

санхүүгийн бүтээгдэхүүний эрэлт өссөн юм бэ гэхээр “Цагаан алт”, “Хүнсний хувьсгал” зэрэг бусад салбаруудыг дэмжих систем маш их байсан. ЖДҮ дээр ч гэсэн манайх хамрагдаж ирээгүй.

Ер нь үндсэн шалтгаан нь дотоодын нийт бүтээгдэхүүнд бид энэ үйлчилгээний экспорт оруулж тооцохгүй байгаа юм.

Дотоодын нийт бүтээгдэхүүнд аялал жуулчлалын салбарын экспортыг орлогыг оруулаад тооцдог болох юм бол бид төрөөс хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагуудын төсөл, хөтөлбөрүүдийг аль салбар луу нь илүү түлхүү хэрэгжүүлэх юм бол эдийн засгийн гарц маань хаашаа чиглэгдэх юм бэ, аль нь яаж нэмэгдэх юм бэ гэдэг энэ асуудлаа шийдэж болох юм.

Тэгэхээр дотоодын нийт бүтээгдэхүүнд үйлчилгээний экспортыг оруулах нэгдүгээр асуудал.

Хоёрдугаарт, ер нь цаашдаа магадгүй Эдийн засгийн байнгын хороо, Аялал жуулчлалын дэд хорооноос санаачлаад Эдийн засаг, хөгжлийн яам, мэргэжлийн холбоод, Соёл, спорт, аялал жуулчлалын яамтай олон улсын санхүүгийн институцүүдийг аялал жуулчлалын салбар луу оруулж ирэх.

Одоо миний мэдэж байгаагаар ADB (Asian Development Bank), EBRD (European Bank for Reconstruction and Development) энэ ногоон технологи эрчим хүч, хөдөө аж ахуй руу маш их орж байгаа.

Гэтэл байгаль орчин дээр явагдаж байгаа ганц эдийн засгийн салбар чинь аялал жуулчлал байгаа.

- Бидэнд технологийн шийдэл хэрэгтэй.
- Зочид буудлуудаа ногоон болгох хэрэгтэй.

Ялангуяа усны нөөцийг бид ашиглаж маш их үйл ажиллагаа явуулдаг.

Тэгэхээр усны нөөц багатай энэ цөлжилтөд нэрвэгдэж байгаа улсын хувьд манай салбарын технологийн шийдэл чухал байгаа.

Тэгэхээр энэ дээр өөр санхүүгийн эх үүсвэрүүд. Зөвхөн төрийн төсвөөс хамааралтай бус эх үүсвэрийг оруулж ирэх. Энэ дээр магадгүй төлөвлөгөө гаргаад ажиллавал бид хамтарч ажиллах ийм боломжтой байна. Баярлалаа.

Н.Батсүмбэрэл: Сая С.Баясгалан дарга үг хэллээ. Нэрээ хэлээд. Протоколд орно.

С.Амгаланбат: С.Амгаланбат байна. Түрүүн С.Баясгалан дарга хэллээ.

Миний санал ер нь аялал жуулчлалын салбарыг өөрийг нь өөрөөр нь санхүүжилтээ олоод бие даагаад явуулах төсвийн хараат байдлаас гаргах юм. Энэ хүрээнд бид 2023 оны Аялал жуулчлалын тухай хууль дээр орсон. Тэгэхдээ яг тэр хуулийн яг амин сүнс нь тэнд алдагдсан. Сангийн асуудал байсан.

Тэгэхээр энэ бол 800 мянган жуулчин ирдэг гэж бодоход нэг жуулчнаас 5 юм уу, 10 долларын **tourist tax** байдаг шүү дээ. Гадаад улсууд байдаг шиг аваад явахад бол бид жилдээ юу гэдэг юм 8-аас 10 сая доллар багаар бодоход авна.

Үүгээрээ эргүүлээд жил болгон одоо энэ олгогдож байгаа хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээ хийгээд явах, тэр авиа компанийн дотация олгох, өвлийн аялал жуулчлалаа дэмжих гээд яг энэ бол тогтмол эх үүсвэртэй болгоод өгөх юм бол маш зөв.

Тэгэхдээ энэ эх үүсвэрийг хэн зарцуулах вэ, яах вэ ийх вэ гэдгийг маш зөв болгохгүй бол нөгөө өмнөх хэцүү сангуудын асуудлаар ороод эвгүй болох магадлалтай.

Тэгэхээр түүн дээрээ тэр 26.1 энэ тэрээ нэгмөсөн хуульдаа өөрчлөлт оруулж болдог нэг тийм асуудал байна.

Хоёр дахь асуудал нь, П.Мөнхжаргал захирлын түрүүн хэлсэн дээр би нэмээд хэлье.

Манай улсын гадагшаа гарч байгаа **outbound** аяллын мөнгөний тодорхой хэсэг нь гаднын эйрлайнууд орж ирээд Вьетнам болон Хятадын эйрлайнууд нисээд байгаа.

Үүнийг Их Хурлын тогтоол болгодогсон уу, Зам, тээврийн яаманд нэг чиглэл өгдөгсөн үү, Та бүхэн нэн даруй хийгээд өгөх юм бол тодорхой хэмжээний мөнгө. Энэ чинь нийт аялагчдын юу гэдэг юм, мянган долларын багц аяллын бараг 700 доллар нь тийзний үнэ байхгүй юу.

Тэгээд ингэж бодоод үүнийг гаднын эйрлайнууд аваад явж байна. Энэ бол ерөөсөө Монголд орж ирж байгаа аялал жуулчлал биш Монголоос урсаж байгаа мөнгө учраас дотоодын эйрлайнууддаа дэмжих гэдэг ийм энэ хүрээндээ мөнгөө дотооддоо авч үлдэх хэрэгтэй байгаа.

Н.Батсүмбэрэл: Индрийн микрофон хийе.

Б.Ижилмөрөн: Баярлалаа. Б.Ижилмөрөн.

Би энэ “ЧӨЛӨӨЛЬЕ” аянд л жолооч нарынхаа асуудлыг шийдмээр байгаа.

→ Хуулийн нэг заалт байна.

→ Сая шинээр батлагдсан стандарт хоёр л байна.

Энэ хоёр ерөөсөө 75 хувь нь. Тийм ээ. 1000 жолоочийн 75 хувийг нь боомилчлоод байна.

Тэгээд Та бүхэн минь үүнийг маш шуурхай. 4 сарын 10-д боллоо. 5 сарын 10-наас жуулчны улирал эхэлнэ. Тэгээд бидэнд нэг сарын л хугацаа байна. Энэ дээр маш шуурхай нэг арга хэмжээ, зохицуулалтыг авч өгөөч ээ.

Жолооч нарын маань хувьд ер нь техник хэрэгслээ солино, шинэчилнэ гэдгийг бүгд ойлгосон байгаа. Энэ нэг ийм шилжилтийн цаг хугацааг нь олгоод, жолооч нарт маань нэг боломжийг нь өгөөч ээ.

Одоо жишээ болгоод хэлэхэд торгох процесс гэхэд л Дундговь аймаг дээр нэг зөрчилтэй тээврийн хэрэгслийг зогсооно. Зам дээр, товчоон дээр зогсооно. Зогсоогоод түүнд нь шууд манай цагдаа шиг пос ч юм уу уншуулаад шууд торгохгүй. Тэрийг заавал дагуулаад аймгийн төв дээр байх Авто тээврийн үндэсний төв дээрээ очно, оффис дээрээ очно.

Оффис дээрээ очоод. Тэнд тэр оффисын гаднах дүр зураг бол ер нь 7 дугаар сард байна шүү дээ хашаа дүүрэн машинуудыг эгнээгээр нь зогсоосон. 45-ын суудалтай автобусыг тэр чигээр нь аваачаад манай хууль дүрэм ийм байдаг гээд 45 хүнтэй суудалтай автобусыг Авто тээврийн үндэсний төвийнхөө хашаанд хийгээд ингээд торгож байгаа процесс нь.

Жолооч нар маань сүүлдээ аргаа бараад түргэн шуурхай торгоод өгөөч ээ, бид явъя, ажлаа бодъё гэхээр тэгэхгүй ээ. Би шийтгэл бичнэ гээд 4 хуудас юм бичиж байна. Дахиад тэр шийтгэлийг тээврийн прокурортоо хянуулдаг юм байна.

Тэгээд тээврийн прокурор түүн дээр заавал хянаад гарын үсэг зурах юм байна.

Бүр ийм аюултай үзэгдэл. Энэ дэндүү. Хүнд суртал дэндүүгийн дэндүү байна. Болдог бол чөлөөлмөөр байна.

Ер нь жолооч нар тээврийн хэрэгслээ жил бүр улсын үзлэгт оруулж байгаа шүү дээ. Тээврийн хэрэгсэл бүрэн бүтэн байгаа. Жолооч эрхийн үнэмлэхтэй. Дээр нь сургалтуудад хамрагдсан тусгай жолооч нар байгаа юм.

Ингээд л зүгээр хүн тээвэрлэлт явахаар хориглоод ингээд нэг хүндрэл үүсгээд байгаа. Маш хэцүү. Ерөөсөө үүнийг минь Та бүхэн сайн ойлгоод аваарай. Маш их баярлалаа.

Н.Батсүмбэрэл: Индрийн микрофон шинээр нээе.

С.Алтантуяа: Түрүүний юунд товчхон. Би хариулж амжаагүй.

Юу гэвэл өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэхийн тулд ерөөсөө хамгийн нэг номерт байршуулах хэрэгсэл, зуучны бааз, амралтын газар, ресортын цахилгааны хөнгөлөлтийн асуудал нэг номер.

Энэ дээр Засгийн газраас 360 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэнд маш их талархаж байгаа.

Ер нь цаашид сэргээх эрчим хүчийг ашиглах тал дээр төрөөс бодлого боловсруулахад тус дэм үзүүлбэл маш чухал байгаа юм.

Хамгийн чухал асуудал өнөөдөр тусгай хамгаалалттай газар нутгийн хуульд 10 гаруй удаа хэлэлцүүлэг хийхэд манай холбоо идэвхтэй оролцсон. Энэ дээр бол 5 жил гэдгийг 15 жил болгох хүсэлт тавьсан боловч 10 жил болсон явж байгаа.

Үүнийгээ 15 жил болгох дээр анхааръя гэсэн хүсэлт байна

Хоёрдугаарт, энэ 15 жилийн юуг дагаад нөгөө 5 жил байгаа газрын хянан баталгаа, нарийвчилсан үнэлгээ, менежментийн төлөвлөгөө эд нарыг адилхан 15 жил болгохгүй бол болохгүй байна.

Дээрээс нь Байгаль орчин, аялал жуулчлалын яаман дээр сунгалтын асуудлыг их удах юм. Яг ингээд л материалаа өгчхөөд л 4 жил болоод л арай хийгээд сунгаад гараад ирэхээр 5 дахь жил нь дууссан. Дахиад сунгуулна.

Энэ одоо ч, өнөөдөр ч энэ асуудал маш хүнд байгаа.

Дээрээс нь өмчийн асуудал яригдаж эхэлсэн. Ялангуяа хотыг тойрсон болон Тэрэлжийн баазууд дээр газрыг давхцуулж өгөх, хаусын газар өгөх, газрын гэрчилгээг нь тусгай амралтын газрын газраас цуцалчхаад нийслэлийн мэдэл болонгуут тэр гэрчилгээг нь өгөхгүй удаан байлгах хүнд суртал гаргаж байна. Эд нарыг эргэж харах цаг болсон гэж үзэж байна.

Дээрээс нь саяын тэр НӨАТ-ын асуудал дээр тур оператор бол төлдөггүй. Гэтэл жуулчны баазууд дээр байгаа ресторан, кофе, лоунж, эд нар татвартай. Энэ татваруудыг чөлөөлөх асуудал дээр анхаарал хандуулж өгөөч ээ.

Зээлийг ер нь ил тод, хүртээмжтэй, маш багаар ч хамаагүй өгөхгүй бол маш их асуудал үүсэж байна. Одоо тоо нь нэмэгдээд л байна. Ерөөсөө авч чадаагүй байхад нь нөгөөдөх нь дууссан гээд асуудал яриад. Тэгээд энэ асуудалд анхаарч өгөөч ээ гэж хүсэж байна. Баярлалаа.

Н.Батсүмбэрэл: Индрийн микрофон. Сая хэн? С.Алтантуяа. Тийм ээ. Сая С.Алтантуяа үг хэлсэн.

М.Нарангэрэл: Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны гүйцэтгэх захирал М.Нарангэрэл.

Нийслэл хотын аялал жуулчлалын чиглэлээр авч байгаа 2 хувийн татварын асуудлыг бидэнд буцаагаад нийслэл хотыг жуулчдад ээлтэй хот болгоход зориулсан төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх, эсвэл үйлчилгээний байгууллагуудын татварын хөнгөлөлтөөс буцааж урамшуулал олгох, жуулчин авч ирсэн талаар нь урамшуулал болгох дээр нийслэл хоттой энэ бодлогыг уялдуулж өгөхөд Их Хурлын зүгээс чиглэл өгч, эсвэл энэ татварын зарцуулалтыг юунд зарцуулдаг тал дээр бизнес эрхлэгчдэд нээлттэй болгох тал дээр ажиллаж өгөөч ээ.

Хоёрдугаарт, манайх визний чөлөөлөлтийн сунгалтын асуудал жил болгон яваад байна. Гэтэл зочлох жилийг 2023-2028 оны хооронд гээд зарласан байж байдаг.

Тэгээд жил болгоны аяллын улирал эхлэхэд бид виз сунгагдах эсэхээ мэдэхгүй. Мэдээлэл маш ойлгомжгүй. Тэгээд 12 сар нэлээн гарч байж энэ виз сунгагддаг асуудлууд яригдаад байна.

Тэгэхээр визээс чөлөөлж байгаа энэ асуудлыг хугацааг нь наашлуулж өгөөд, бас нэлээн хүртээмжтэй байдлаар төлөвлөлтийг хийдэг болгож өгөх гэсэн хүсэлт тавимаар байна.

Хятадын жуулчдыг бүлгээр аялуулах визний асуудал хурц байгаа. Яагаад гэхээр гэр бүлээрээ цахим виз мэдүүлдэг. Тэгэнгүүт аав, ээж хоёрынх нь гарах, эсвэл хоёр хүнийх нь гарахгүй байх тохиолдлууд аягүй их тохиолдож байгаа.

Тэгэхээр Хятад жуулчдын бүлгээр аялуулах цахим визний асуудлыг Гадаад хэргийн яамтай хамтарч түргэн шуурхай болгох асуудал дээр Их Хурлаас, Аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хорооноос чиглэл хүргүүлж өгөөч ээ гэсэн ийм хүсэлт байна.

Н.Батсүмбэрэл: Баярлалаа. Аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын мэдээлэлтэй холбогдуулан үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд.

Р.Батболд: Хэдүүлээ баахан асуудал ярьлаа.

Би зүгээр нэг санал хэлэх гээд байгаа юм. Яагаад та нар нийлээд явж болдоггүй юм бэ гээд. Зүгээр чиглэл чиглэлээрээ та нар холбоодоо байгуулаад. Юу гэдэг юм. Тээврийн салбар гэхэд автобусны холбоо, өшөө жижиг тээвэр ч байдаг юм уу, дунд оврын автобус ч гэдэг юм уу гэх мэтчилэн зүгээр эд нарыгаа нийлүүлээд. Тэгээд ганцхан холбоо байгаа юу. Тийм ээ. Эсвэл дахиад нэг өөр холбоо байгаа юу. Байхгүй юу.

Танайх бол Солонгос. Гэтэл цаана чинь дахиад Америк, Франц гээд гээд байгаад байна шүү дээ. Эд нарыгаа нийлүүлж болдоггүй юм уу гэж байхгүй юу.

Би салбаруудаа бүгдийг нь ингээд өөрс өөрсдөө нэг л холбоотой. Тийм ээ. Тэгэхдээ. Тэндээсээ төлөөлөл нь гараад board байгуулаад удирдаад явж болдоггүй юм уу л гээд байгаа байхгүй юу.

Одоо тэгээд яагаад хоёр холбоо болчихоод байгаа юм бэ гэдэг. 2 ч юм уу, 3 ч юм уу. Хэд ч байгаа юм бүү мэд. Аялал жуулчлалын холбоо гээд л цаана нь байж байна. Дахиад хэдэн холбоо байгаа юм бүү мэд шүү дээ.

Тэгэхээр Та нар нэг нийлээд тийм юм хийж болдоггүй юм уу гээд байгаа юм. Би зүгээр тийм санаа л хэлээд байгаа байхгүй юу. Одоо би ойлгож байна. Хуулийнхаа дагуу нэг байгууллага байгуулагдаад тэгээд бид энд байж байна, боард нь бид байна гэж байна. Гэтэл цаана чинь өшөө дахиад байгаад байна шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр бид хуулийнхаа дагуу байгуулагдсан боардтой. Бид аваад явах ёстой биш. Тийм ээ. Бүх салбаруудаа бид хамруулъя. Тэгэхийн тулд яах ёстой юм гэдэг ийм зүгээр бодлогын ажил хийх ёстой юм уу л гэж зүгээр бодоод байна.

Тэгээд манай яамтай би түрүүчийн уулзалтаар санал хэлээд байсан шүү дээ. Нөгөө Тэрэлж чинь уулын ам болгонд. Ам битгий хэл жалганыхаа хоёр талд нь гэр барьчхаад л баазууд гээд яваад байдаг. Одоо баазуудын холбооны тэргүүн хүртэл хэлээд байна шүү дээ. Үүнийгээ бид яаж зохицуулах юм бэ. Зарим нь зөвшөөрөлтэй, зарим нь зөвшөөрөлгүй. Тэгээд ингээд харахаар бааз юм шиг ийм юм яваад байдаг.

Тэгэхээр түүн дээрээ нэг бодлого гаргадаг ч юм уу. Тэрэлж бол бид жилд тэдэн жуулчин аваад байгаа юм байна. Зундаа тэд байдаг юм байна. Тэгээд гарагуудаар нь хуваавал нэг дэхээс тав дахид бид тэд байдаг юм байна.

Ингэж хуваачхаад тэр зохистой тоонд нь баазуудаа байгуулж болохгүй юм уу. Зарим нэгийг нь буулгавал яасан юм бэ. Зарим нь газар нь байгаад байдаг. Үйл ажиллагаа явуулахгүй хаасан газрууд ч харагдаад байдаг. Тийм ээ. Эсвэл бүр энэ гэр лүү чинь яаж орж хонох юм гэмээр юмнууд байгаад байдаг. Тийм ээ. Гадаа жорлонтой гэдэг юм уу.

Үүнийгээ сайжруулаад тэр зохистой яг тоо хэмжээнд нь барьж болохгүй юм уу.

Тэгээд бид бас үнийн бодлогоороо бариад. Одоо бид бүгдээрээ дотоодынхоо аялал жуулчлалыг хөгжүүлэе гээд байгаа мөртлөө дотоодоороо аялахаар гадаадад аялснаас хамаагүй үнэтэй болоод байхаар хэн дотооддоо аялах юм бэ.

Тэгээд энэ төр нь дэмжээд өгөөч ээ, та нар дотаци өгөөч гээд байдаг. Бид барахгүй шүү дээ. 1 тэрбум доллар гарсан гэсэн үү. Түүрүүн нэг сард. Тийм. 2 их наяд гэсэн үү.

Үүнийг чинь бид төр засаг яаж дийлэх юм бэ. Дотоодын аялал жуулчлалын салбарууд нь өөрсдөө үүнийгээ бодож нэг бодлого гаргаад хэрэгжүүлэхгүй бол төр та нарт үүнийг чинь өгч чадахгүй шүү дээ. Энэ бол зүгээр шууд хэлэхэд үнэн шүү дээ. Тийм биз дээ.

Тэгэхээр ийм санаа байгаад байна. Одоо 300-аас 400 бааз байгаа гэсэн мөртлөө тэнд чинь шавсан л аймаар юм байгаа шүү дээ. Одоо дээрээс нь харах юм бол аймаар болсон. Зүгээр байгалийн зураг авч болохоо байсан. Тийм ээ. Нэг тийшээ хараад л зураг авахаар гэр, эсвэл байшин, гэр, байшин. Уг нь бараг худалч хүнд харагдаж байгаа юм уу, үгүй юу.

Дараагийн асуудал. Тэр нэг хяналт шалгалттай холбоотой асуудлууд яригдаад байгаа юм.

Бид мэргэжлийн хяналтын байгууллагаа татан буулгасанаас болоод байх шиг байгаа юм. Энэ уг нь мэргэжлийн хяналтын байгууллага нь хуучин байсан бол. Эд нар чинь комисс гараад явдаг байсан шүү дээ. Салбар салбарынхан нь нийлээд л.

Тэгээд тийм юм нь байхгүй болчихоод. Одоо яалт ч үгүй... /минут дуусав/

Н.Батсүмбэрэл: Сунгая. Р.Батболд гишүүний микрофоныг нээе.

Р.Батболд: Яалт ч үгүй хариуцсан салбар болгон нь явж шалгахаас л өөр аргагүй болоод байгаа л тийм асуудал байгаа юм л даа.

Одоо жуулчны салбар чинь өөрөө эрсдэлтэй салбар шүү дээ. Энэ дандаа хүний амь нас, юу гэдэг юм эрүүл мэндийг дааж явж байгаа.

Зочид буудалд жишээлэх юм бол та яагаад нөгөө мал эмнэлэг ороод ирж байгаа юм бэ гээд. Тийм ээ. Эрүүл мэндийн яам ч юм уу. Ямар хамаатай юм бэ гээд. Үгүй ээ, тэр чинь хүнсний аюулгүй байдлаас эхлүүлээд л зөндөө асуудлууд бий шүү дээ.

Тэгээд л зоонозын өвчин судлал гээд л, нэг халдварт өвчин ч байдаг юм уу гээд. Тэгэхээр эд нар нь салаад явсан болохоор л тийм юмнууд болоод байгаа. Тэрийгээ харин яаж буцааж нэгтгэж нэг болгох ёстой юм. Стандартыг бол мөрдүүлэхийн тал дээр бол би яг тэр талыг бол барьж явдаг хүн. Шалгалт байх ёстой. Заавал ч үгүй нэг стандартын дагуу бид явж байх ёстой.

Тээврийн салбарын хувьд харамсалтай байгаа юм. Оношилгоонд ороод тэнцсэн машиныг яагаад явуулдаггүй юм гэдэг л асуудал байгаа юм. Тийм биз дээ.

Н.Батсүмбэрэл: Б.Тулга гишүүний микрофоныг нээе.

Б.Тулга: Та бүгдийнхээ санал бодлыг сонслоо. Энэ танилцуулгыг ерөнхийд нь авч үзлээ. Тэгээд хоёр, гурван санал байна. Байнгын хороон дарга аа.

Юуны түрүүнд Байнгын хороон даргадаа талархал илэрхийлье.

Аялал жуулчлалын дэд хороогоо ойр ойрхон хуралдуулаад жаргал зовлонг нь, тулгамдаж байгаа асуудлуудыг нь сонсож шийдэх. Үүнийг эрэлхийлж байна гэдэг маш сайн. Н.Батсүмбэрэл даргад албан ёсоор. Байнгын хорооны гишүүн биш шүү, би чинь. Дэд хорооны. Намайг хассан байна лээ шүү дээ та нар. Тэгэхээр сул гишүүний хувьд хэлж байгаа юм шүү.

Тэгээд хоёр, гурван санал байна. Өнөөдөр зөвхөн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, компанийн төлөөллийг нэг талыг сонслоо.

Тэгэхээр эд нарын маань ярьж байгаа тулгамдсан асуудлууд эргээд нөгөө талдаа очихдоо бүгд нэг нэг яамны газрын дарга, газар, хэлтэс дээр очиж тулдаг юм. Одоо Гадаад яаман дээр очиж тулж байна гэж байна, Авто тээврийн үндэсний төв дээр очиж тулна. Тэгээд Сангийн яаман дээр гээд тулна.

Тийм учраас дараагийн дэд хорооны хурлаа эндээсээ тодорхой төлөөлөл байлгаж байгаад эндээс гаргасан тодорхой чиглэл юу гэдэг юм Их Хурлын Байнгын хорооны тогтоол ч юм уу, тогтоолын төсөл бэлдээд яг энэ дээр энэ төрийн агентлагуудыг дуудаж нэг хэлэлцүүлэг хиймээр байна.

Ингээд эндээс энэ дундын шийдвэрийг олоод. Тэгээд тэрийгээ Их Хурлаар баталгаажуулах уу, хууль өөрчилж баталгаажуулах уу, Засгийн газар дээр шийдвэр гаргах уу гэдгээр томьёолоод явбал зүгээр юм шиг санагдаж байна.

Ер нь Монгол Улсад явж байгаа. Түрүүн ярилаа. С.Баясгалан хэлэв үү, хэн хэлэв. Нөгөө дотоодын нийт бүтээгдэхүүн энэ салбар орж тооцогддоггүй гээд. Үүнийг заавал ч үгүй оруулж тооцох ёстой. Ер нь Монгол Улс руу валютын урсгал чиглүүлж байгаа, хамгийн олон ажлын байр бий болгож байгаа гэвэл яах аргагүй бараг номер нэг дээр аялал жуулчлалын салбар орно.

Тийм учраас үүнийг илүү тодорхой түвшинд гаргаж, энэ салбарын ач холбогдлыг ойлгуулах ажил бидэнд их чухал байна.

Тэр гаргаж байгаа саналуудыг сонслоо. Нисэх, авиа компаниуд дээр гарч байгаа проблемууд байна.

Тэр хуулийн амин сүнсийг нь аваад хаясан гээд. Үүнийг харин дахиж оруулмаар юм шиг санагдлаа. Тусгайлан. Өөрөөр хэлбэл энэ санг төр удирдахгүй. Төрийн хэн нэгэн эрх мэдэлтэн, төрөөс томилсон нэг хүн удирдалгүйгээр энэ санг түрүүн яриад байгаа нэгдсэн холбоо байна шүү дээ. Манай холбоодын нэг юм бол та нар нэгдсэн нэг л холбоо байх ёстой. Монгол Улсад.

Тэр холбооныхоо удирдах зөвлөл боардоороо шийдээд тэр сангаа зохицуулдаг, зарцуулдаг. Тэр хяналтаа олон нийтдээ тавиад явж байдаг ийм хэлбэр лүү л орох ёстой.

Тэгэхгүй төрөөс ямар нэгэн байдлаар санг удирддаг зохицуулдаг л болох юм тэгээд л будаа болно. Тэртээ тэргүй болтол аялал жуулчлалын салбар луу төр гүнзгий орж юу гэдэг юм хүн амьтан томилдог, компани байгуулдаг биш байгаа энэ үед тэр сангийн амин сүнсийг бид засаж өгөх нь бидний үүрэг юм байна шүү гэдгийг манайхан аягүй сайн ойлгомоор байна. Ингэж бие даалгаж явуулахгүй бол тэр сан дээр юу гэдэг юм, хууль дээрээ нэг төрийн байгууллага, Аялал жуулчлалын яам шийднэ ээ л гэвэл тэгээд дуусна шүү.

Тийм учраас үүнийг одоо явж байгаа тэр банкууд дээр зээл өгч байгаа хэлбэр, арилжааны хэлбэрээр хяналтаа тавьдаг энэ юм руу оруулж өгөөд явах нь зөв.

Миний ойлгосноор сая нийслэл дээр аялал жуулчлалын 2 хувийн татвар гэж байгаа юм уу. Сантай юм байна шүү дээ. Сая сантай гээд хэллээ шүү дээ. Эрх зүйн хувьд боломжтой. Тэгэхдээ байгуулаагүй л байгаа юм байна шүү дээ. Нийслэлийн татвар 2 хувийг яриад байна уу. Аялал жуулчлалын татвар гэж яваад байна уу. Нийслэлийн татвараа л ярьж байгаа биз дээ.

Иймэрхүү байдлаар эхний ээлжинд нийслэлд чиглэл өгөөд явах нь зөв юм байна гэсэн ийм саналуудыг хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Н.Батсүмбэрэл: Улсын Их Хурлын гишүүд үг хэллээ.

Хуралдаан даргалагчийн хувьд хоёр, гурван зүйлийг анхаарах ёстой гэж бодож байна.

Өнөөдөр Лхагва гараг дуусаж байна. Маргааш Пүрэв, Баасан гээд хоёр ажлын өдөр байгаа. Энэ ажлын хоёр өдөрт холбоод, байгууллагууд саналаа бичгээр өгчих. Дэд хороон дээр. Ямар асуудлууд тулгамдаад байгаа юм бэ. Аль яаман дээр, аль агентлаг дээр, авто тээврийн төв дээр, хяналт шалгалтын байгууллага дээр, Гадаад харилцааны яаман дээр. Тэр асуудлуудаа бүгдийг нь бичээд өгмөөр байна.

Тэгээд бид нэг дэх өдрөөс манай хүмүүс сууж байгаад аль алийг яаж хийж болохоор байна. Эргээд хоёр талаа байлцуулж байгаад нэг ярилцъя.

Яаж тэр 45 хүний суудалтай автобусыг удаан хугацаанд зогсоохгүйгээр явуулах вэ. Тэр авиа компани дээр дотоодын нислэгээ яавал дэмжих вэ. Энэ бүхнийг Та бүхэн саналаа өгвөл тэр санал дээр тулгуурлаад явъя. Яам бас саналаа өгчих. Яам саналаа өгөөд тэр хуучин явж байсан тэр сантай холбоотой хуулийн төслөө өгмөөр байна. Тэгвэл дэд дэд хороонд байгаа гишүүдэд.

Б.Тулга гишүүндээ талархал илэрхийлье. Дэд хорооны гишүүн биш боловч аялал жуулчлалын салбарт санаа тавьж, өөрөө ажиллаж байсан сайдынхаа хувьд энэ асуудлыг бүгдийг нь мэдэж ярьж байгаа явдал Та бүхэнд их хувь нэмэр болно.

Тийм учраас дэд хорооны гишүүдэд санаачлаад хуулийг өргөн барьж болж байна. Энэ дээр хэдүүлээ ажиллацгаая.

Тэгээд өнөөдрийн дэд хорооны хурал 2 цаг 12 минут үргэлжиллээ. Хуралдаан үр дүнтэй боллоо гэж үзэж байна. Та бүхэнд баярлалаа.

Хуралдаан хаалаа. /алх цохив/

Хуралдаан 2 цаг 12 минут үргэлжилж, 19 цаг 24 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД